



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН НЭР: “АЙМГИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР НӨЛӨӨ”

АУДИТЫН КОД: ДОА-2022/32-ШТА-ГА

ХАЛАМЖИЙН БОДЛОГО ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
БОДЛОГОТОЙ УЯЛДУУЛААГҮЙ БАЙНА

Баян-Өлгий аймаг 2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас: 70422954 цахим хуудас: Khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 70422930 цахим хуудас: jenisbekh@audit.gov.mn
Ахлах аудитор: Х.Манаргүл
Утас: 95429524
Цахим хуудас: manargulx@audi.gov.mn
Ахлах аудитор Д.Назгүл
Утас: 99427301
Цахим хуудас: nazguld@audit.gov.mn
Ахлах аудитор М.Айнур
Утас: 94159291
Цахим хуудас: Ainurm@audit.gov.mn
Аудитор Ж.Назгүл
Утас: 99668909
Цахим хуудас: nazgulj@audit.gov.mn
Аудитор Х.Еркебулан
Утас: 99999844
Цахим хуудас: Erkebulan.Kh@audit.gov.mn

Энэхүү аудиттай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
ягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

Агуулга

Агуулга

2

Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товъёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
БҮЛЭГ 1. ХАЛАМЖИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА	
8	
1.1 Халамжийн сангаас олгох үйлчилгээний зарим эрх зүйн зохицуулалт оновчгүй байна	8
1.1.1 Халамжийн сангийн хууль эрх зүйн орчин бүрдсэн боловч зарим хууль, журмуудын холбогдох заалтууд зөрчилтэй байна	8
1.1.2 Халамжийн бодлого нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой уялдаагүй байна	9
1.1.3 Халамжийн үйлчилгээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй харьцуулан тооцож олгох бодлого байхгүй байна	11
1.2 Халамжийн үйлчилгээнд шаардлагатай орон нутгийн төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна	12
1.2.1 Халамжийн сангийн арилжааны банкн дахь дансны үлдэгдэл, хүүгийн орлогыг төвлөрүүлсэн байна	12
1.2.2 Халамжийн үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг үндэслэлтэй төлөвлөсөн байна	13
1.2.3 Орон нутгийн төсвөөс халамжийн үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг төлөвлөснөөс 1-3 дахин бууруулж баталсан байна	15
БҮЛЭГ 2. ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА	17
2.1. Халамжийн үйлчилгээнд зорилтот эмзэг бүлгийн иргэдийг хамруулан ажилласан байна	17
2.1.1 Халамжийн үйлчилгээ зорилтот эмзэг бүлгийн иргэдэд хүрч байна	17
2.1.2 Судалгаагаар иргэдийн 80.3 хувь нь халамжийг бэлэн мөнгөөр олгох нь үр дүнтэй байна үзсэн байна	17
2.1.3 “www.ehalamj.mn” нэгдсэн системийн халамжийн цахим мэдээлэл нь бусад төрийн байгууллагуудын мэдээллийн баазтай уялдаатай байна	18
2.1.4 Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан байна	19
2.2. Халамжийн үйлчилгээг хууль журмын дагуу үзүүлсэн байна	19
2.2.2 Хууль, журамд заасан шалгуур хангаагүй 126 иргэнд халамжийн тэтгэвэр олгосон байна	21
2.2.4. Халамжийн үйлчилгээг үзүүлэхдээ давхацлыг тооцож үзээгүй байна	30
2.3 Халамжийн сангийн хөрөнгийг батлагдсан төсвийн дагуу зарцуулсан боловч 419.5 сая төгрөгийг хууль зөрчиж олгосон байна	31
2.3.1 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлсэн байна	31
2.3.2 Халамжийн тэтгэврийн сангаас 2020-2021 онд 419.5 сая төгрөгийг хууль, журам зөрчиж олгосон байна	31
2.4. Хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн байна .	36
2.4.1 Хүнсний эрхийн бичгийг эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөлд олгожээ	36
2.4.2 Хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээнд хамрагдсан өрхөөс зохих түвшинд хасалт хийгджээ	37
2.4.3 Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүрийн сонгон шалгаруулалтыг 2019 онд зохион байгуулж, 2020 онд гэрээг сунгасан байна	38

2.4.4 Хүнсний эрхийн бичгээр үйлчилдэг дэлгүүрүүдэд хяналт тавьж ажиллаагүй байна	
40	
2.4.5 Хүнс тэжээлийн дэмжлэг нь ядуурлыг бууруулж, зорилтод бүлгийн иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд төдийлөн нөлөө үзүүлээгүй байна	42
2.4.6 Хүнс тэжээлийн дэмжлэг авсан иргэдийг журамд заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулан ажиллажээ.....	43
БҮЛЭГ 3. ХАЛАМЖИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА	44
3.1 Халамжийн сангийн үйл ажиллагааны тайлан, мэдээг хугацаандаа тайлагнаж ажилласан байна	44
3.1.1 Нийгмийн хөгжлийн үйлчилгээ, халамжийн үйлчилгээний тайлангийн үр дүнг тооцож, холбогдох газарт тайлагнаж ажилласан байна	44
3.1.2 Халамжийн үйлчилгээг цахимаар мэдээлж байгаа нь иргэдэд хүртээмжтэй биш байна	45
3.1.3 Шилэн дансны мэдээллийг хугацаанд байршуулж ажилласан байна	47
3.2 Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг 2020-2021 онд цахимаар хэрэгжүүлсэн нь үр нөлөөгүй байна.....	47
3.2.1 ХХҮЕГ-аас халамжийн сангийн 2020-2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит, мониторинг хийж, дүгнэлт гаргаагүй байна	47
3.2.2 ХХҮГ-аас 2020-2021 онд дотоодын хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна	48
3.2.3 Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээнд шалгалт хийсэн байна	50
ДҮГНЭЛТ: 51	
ЗӨВЛӨМЖ:.....	54
ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ НЭГДСЭН ТАЙЛАНГИЙН ЗӨВЛӨМЖИД ОРУУЛАХ САНАЛ:.....	54
БӨА ТАГ ТУШААЛ	55
ХАВСРАЛТУУД	56

Товчилсон үгийн тайлбар

АДЗ	Амьжиргааг дэмжих зөвлөл
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНОТХҮ	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ
ӨМНС	Өрхийн мэдээллийн нэгдсэн сан
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХЭТББ	Төрөөс хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн холбоо
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХБХ	Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл
ХЭХАХМ	Хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭДДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сан
ХЭСЗ	Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
ХЗЗМНС	Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан
ХШҮДАХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ЭХМК	Эмнэлэг, хөдөлмөр магадлах комисс

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн хүн амын тоо	10
Хүснэгт 2	Өлгий сумын амьжиргааны доод түшингээс доогуур орлоготой болон эмзэг бүлгийн өрх	10
Хүснэгт 3	Халамжийн сангийн арилжааны банкн дахь дансны үлдэгдэл	12-13
Хүснэгт 4	2020-2022 оны төсвийн төсөөллийн санал болон батлагдсан төсөв	13-14
Хүснэгт 5	Сум багийн хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд ноогдож байгаа хүн амын тоо	15
Хүснэгт 6	2020-2022 оны орон нутгийн төсвийн төсөөллийн санал болон батлагдсан төсөв	16
Хүснэгт 7	2020-2022 онуудад олгосон халамжийн үйлчилгээний хэлбэр	18
Хүснэгт 8	Сум багийн амьжиргаа дэмжих зөвлөлийн	20
Хүснэгт 9	Халамжийн тэтгэвэрт хийсэн түүвэр шалгалт	22
Хүснэгт 10	2020-2022 онд олгосон бүлгийн төслийн задаргаа	24
Хүснэгт 11	2020-2022 онуудын ахмад настанд амралт, сувиллын газарт амрах эрхийн бигийн хөнгөлөлтийн судалгаа	25
Хүснэгт 12	2020-2022 онуудын түлш худалдан авах мөнгөн тусламжийн талаар судалгаа	25-26
Хүснэгт 13	ХБИ-д 2020-2022 онуудад түлш худалдан авахад нь жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн талаар судалгаа	27
Хүснэгт 14	Аймгийн халамжийн үйлчилгээний давхцыг тооцож ирүүлсэн судалгаа	30-31
Хүснэгт 15	Аймгийн нийгмийн халамжийн сангийн 2020-2002 оны орлого ба зарцуулалтын задаргааны судалгаа	31-32
Хүснэгт 16	Халамжийн сангийн 2020-2022 оны батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа	32
Хүснэгт 17	Аймгийн нийгмийн халамжийн сангийн 2020-2021, 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлүүдийг харьцуулсан судалгаа	33
Хүснэгт 18	Орон нутгийн төсвөөс халамжийн үйлчилгээнд 2020-2022 оны хагас жилийн байдлаарх судалгаа	36
Хүснэгт 19	2020-2022 онуудад хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээнээс хасагдсан өрх, хүний тоо	37
Хүснэгт 20	2020-2022 онуудад хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээнээс түдгэлзүүлсэн өрхийн тоо	38
Хүснэгт 21	Баян-Өлгий аймгийн хэмжээнд хүнс тэжээлийн дэмжлэгт өрхийн тоо	43

График товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
График 1	2017-2020 онуудын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ	11

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Аймгийн нийгмийн халамжийн сангийн 2020-2022 оны орлого ба зарцуулалтын судалгаа	32
Хавсралт 2	Халамжийн сангийн 2020-2022 оны батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийн судалгаа	33
Хавсралт 3	Аймгийн Халамжийн сангийн 2020-2021 он болон 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг харьцуулсан судалгаа	34

Аудит үндэслэл, эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл
	Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан ТАБ-ын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан аудитын сэдэв, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн хийв.
Аудитын зорилт	Халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөөд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: • Халамжийн сангийн бодлого үр нөлөөтэй, сангийн хөрөнгийг үндэслэлтэй төлөвлөсөн эсэх; • Халамжийн үйлчилгээг арвилан хэмнэлттэй, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; • Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр нөлөөтэй эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад “Аймгийн Халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө”-д хийх гүйцэтгэлийн аудитад аймаг, сумын халамжийн сангийн 2020-2022 оны үйл ажиллагааг хамруулан шалгалаа.
Аудитын хязгаарлалт	
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУБ /INTOSAI/-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан баримт материалыг шалгах, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга, судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Х.Манаргүл, М.Айнур, Д.Назгүл, аудитор Ж.Назгүл, Х.Еркебулан, нар хамтран хийж гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөөг 2022 оны 09 дүгээр сарын 01-ны өдөр хүлээн авч, талбарын ажлыг 2022 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын дэд тайланг 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн дотор бэлтгэж, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 30-ны дотор нэгтгүүлэхээр хүргүүлэв.

Хүндрэл бэрхшээл

Аудитын хамрагдах хүрээ өргөн, аудит хийх хугацаа бага байснаас халамжийн сангийн 10 төрлийн хөтөлбөрийн 72 үйлчилгээний 2020-2022 оны санхүүгийн баримтыг бүрэн шалгах боломжгүй тул түүврийн аргаар шалгасан

БҮЛЭГ 1. ХАЛАМЖИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

1.1 Халамжийн сангаас олгох үйлчилгээний зарим эрх зүйн зохицуулалт оновчгүй байна

1.1.1 Халамжийн сангийн хууль эрх зүйн орчин бүрдсэн боловч зарим хууль, журмуудын холбогдох заалтууд зөрчилтэй байна

Нийгмийн халамжийн тухай хуулийг 2012 онд баталж, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулж ирсэн байна.

Монгол Улсын халамжийн хууль, эрх зүйн орчин хангалттай бүрдсэн, санхүүжилтийг нь улсын төсөвт тусгаж хэвшсэн, үйл ажиллагаа нь харьцангуй тогтворжсон салбар боловч аудитын дүнгээс үзэхэд зарим хууль, журмын заалтууд зөрчилтэй байна. Тухайлбал:

- Нийгмийн халамжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т “нийгмийн халамж” гэж эрүүл мэндийн доройтолтой, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа”-г заасан. Гэтэл хүн амын өсөлтийг дэмжсэн хүүхдийн мөнгө, цалинтай ээж хөтөлбөр, насны хишиг, ахмадын амралтын хөнгөлөлт зэрэг хуульд заасан нийгмийн халамж гэсэн тодорхойлолттой нийцэхгүй үйлчилгээнүүдийг халамжийн сангаас олгож ирсэн байна.
- Халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Нийгмийн халамжийн тэтгэвэрийг нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу бүрэн болон хувь тэнцүүлэн тогтоосон тэтгэвэр авах эрх үүсээгүй дараах иргэнд сар бүр олгоно”, 12.1.5-д “18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг” гэсэн заалт хэрэгжээгүй байна. Статистик судалгаанаас үзэхэд тус аймагт “18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг эх” 2020 онд 1503, 2021 онд 1217 байгаа боловч 2020-2022 онд өрх толгойлсон эцэг эхийн тэтгэврийн шалгуурыг нэг иргэн хангаж авсан байна. Энэ нь эх 45, эцэг 50 нас хүрэхэд нэг хүүхэд нь 18 нас хүрдэг тул хууль хэрэгжих боломжгүй байна.
- Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд Амьжиргаа дэмжих зөвлөл, 27.2-т “зөвлөлийн бүрэлдэхүүнийг сум, хорооны Засаг даргын санал болгосноор сум, хороонд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж батална” гэж заасан боловч шинэчлэн баталсан Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд сумын ИТХ-ын Тэргүүлэгч гэсэн субъект байхгүй болсон байна.
- Нийгмийн халамжийн тухай хуульд заасан боловсролыг дэмжих үйлчилгээ /сургуулийн өмнөх боловсролын болон ерөнхий боловсролын сургуульд сурч байгаа бол хичээлийн хэрэгсэл, сурах бичиг, дүрэмт хувцасны үнийн хөнгөлөлт/, мөн гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэнд халуун хоол, цайгаар үйлчлэх гэсэн заалтууд бодит амьдрал дээр хэрэгждэггүй байна.

- Засгийн газрын 2014 оны 404 дүгээр тогтоолоор баталсан “Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам”-ын 2.3-т мэдээллийн санг бүрдүүлэхэд ашиглаж байгаа аргачлалыг нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй уялдуулан 3 жил тутамд шинэчлэхээр заасан байна. Гэтэл 2017 оноос хойш өнөөдрийг хүртэл ӨМНС-ийг шинэчлээгүй бөгөөд өнөөдрийн нөхцөл байдалд тохирохгүй хуучирсан мэдээлэлд тулгуурлан хүнсний эрхийн бичгийг олгож байгаа нь холбогдох хууль, журмуудыг хэрэгжүүлээгүй, хоорондын уялдаа холбоогүй байна.

1.1.2 Халамжийн бодлого нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой уялдаагүй байна

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд бодлого төлөвлөлтийг нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байхаар заасан.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдэд заасан хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээрх зорилго, зорилтуудыг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийг 2021-2025 хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж баталсан байна.

Аймгийн хэмжээнд 2016-2020 онд зорилтод бүлгийн иргэдийг хамруулсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т 430.5 сая төгрөг зарцуулж 708 хүн, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-т 188.9 сая төгрөг зарцуулж 240 хүн, “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр”-т 140.1 сая төгрөг зарцуулж 1,136 хүн, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-т 2,147.9 сая төгрөг зарцуулж 4,893 хүн, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т 906.2 сая төгрөг зарцуулж 786 хүнийг тус тус хамруулсан байна.

“Алсын хараа-2050”-д заасан эмзэг бүлгийн өрхийн нэг гишүүнийг ажлын байраар хангах бодлого баримтална” гэсэн заалтын хүрээнд тус аймгийн ИТХ-ын 2020 оны 15 дугаар хуралдаанаар “Аймгийн хөгжлийн 2021 оны төлөвлөгөө”-ний 1.3-т “Халамжаас хөдөлмөр эрхлэлт”-д тэмүүлэх, “Нийгмийн халамж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, зорилтот бүлэг рүү чиглэсэн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, нийт хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, дундаж давхаргын хүрээг өргөжүүлэн, хүн амын ядуурлын түвшнийг бууруулах” чиглэлээр хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлэхээр баталсан байна. Орон нутгийн төсвөөс дээрх хөтөлбөрт ямар нэгэн санхүүгийн дэмжлэг төлөвлөж, батлаагүй байна.

Үндэсний статистикийн хорооноос хоёр жил тутамд ядуурлын түвшний судалгаа явуулдаг ба 2020 онд хийсэн судалгаагаар Баян-Өлгий аймгийн ядуурлын түвшин 22.8 хувь байгаа нь улсын түвшнээс 5.0 хувиар, ажилгүйдлийн түвшин 2022 оны 2 дугаар улирлын байдлаар 16.0 хувьтай байгаа нь улсын түвшнээс 8.2 хувиар өндөр байна.

Мөн Халамжийн сангаас олгож байгаа үйлчилгээг иргэдэд 2022 оны байдлаар авч зэхэд 93.4 хувь нь бэлэн мөнгө хэлбэрээр, 6.6 хувь нь үйлчилгээний хэлбэрээр олгож ирсэн зэргээс үзэхэд зорилтод бүлэгт чиглэсэн ажилгүйдэл, ядуурлыг бууруулах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бодлого нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой уялдаагүй байна.

Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөв хөрөнгө хуваарилагдаагүй, зөвхөн хүнсний эрхийн бичиг авч байгаа иргэнд хөдөлмөр эрхлэх талаар шалгуур тавьсан байна.

Баян-өлгий аймгийн хүн амын тоо 2022 онд 2020 оноос 2.8 хувиар буюу 3011 хүнээр өссөн байна.

Хүснэгт №1			/сая.төг/	
Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 оны хагас жилийн байдлаар урьдчилсан дүн	2022-2020 он
Баян-Өлгий аймаг	105853	108376	108864	3011
Өлгий сум	37310	39711	40076	2766
Бусад сум	68543	68665	68788	245

Эх сурвалж: /Статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас / www.1212.mn//

Аудитын явцад Өлгий сумын амьжиргааны доод түшингээс доогуур орлоготой болон эмзэг бүлгийн өрхийн судалгааг хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №2			/сая.төг/	
Үзүүлэлт	Амьжиргааны доод түшингээс доогуур орлоготой болон эмзэг бүлгийн өрх, хүний тоо		НХСанд хамрагдаж чадахгүй байгаа иргэдийн тоо	
	өрх	Хүний тоо	өрх	Хүний тоо
2022 он	1,174	5,346	349	1,529

Эх сурвалж: /Өлгий сумын ЗДТГазраас/

2022 оны 6 дугаар сарын урьдчилсан байдлаар Өлгий сумд аймгийн нийт хүн амын 36.8 хувь буюу 40,076 хүн амьдардаг байна. Үүний 1,174 өрх буюу 5,346 хүн амьжиргааны доод түшингээс доогуур орлоготой болон эмзэг бүлэгт хамарч байгаа нь Өлгий сумын нийт хүн амын 13.3 хувийг эзэлж байна.

Өлгий сумын нийт хүн амын 3.7 хувь буюу 349 өрхийн 1,529 иргэн халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа нь эмнэлэг хөдөлмөр магдлах комиссоор хөдөлмөр чадвар алдалтаа тогтоолгож халамжийн тэтгэвэр авч байгаад Эмнэлэг, хөдөлмөр магадлах комисс /ЭХМК/-оор дахиж сунгалт хийлгэж чадаагүйн улмаас халамжийн тэтгэвэр нь зогссон, хүнсний эрхийн бичгийн тусламж дэмжлэг авч байгаа өрхийн амьжиргаа дээшилсэн нь тухайн сум багийн Амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн шийдвэрээр тогтоогдсон тул үйлчилгээ нь зогссон, өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаагаар босго оноо нь 320-оос дээш оноотой өрхүүд байгаа тул хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй иргэд байна.

“Халамжаас-хөдөлмөрт” бодлогын хүрээнд хүнсний эрхийн бичиг олгох Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ыг шинэчилж хүнсний эрхийн бичигт хамрагдах хугацааг 2 жил болгож, хөдөлмөрийн насны иргэнийг 2 буюу түүнээс дээш удаагийн тохирсон ажлын байранд зуучлахад татгалзсан тохиолдолд дэмжлэгээс хасах нөхцөлийг тавьж хэрэгжүүлэхээр тусгасан байна.

Мөн аймаг, сумдын Засаг дарга нартай хамтран “Халамжаас хөдөлмөрт” шилжүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэх, эдийн засгийн шинэ сэргэлтийн бодлоготой уялдуулан шинэ ажлын байруудыг бий болгох замаар илүү олон өрхийг хөдөлмөрт зуучлах зорилт тавьж байгаа боловч тодорхой ажлуудыг хийж, үр дүнг тооцсон асуудал байхгүй байна. Өөрөөр хэлбэл халамжийн үйлчилгээг бодлогын хувьд аль болох үйлчилгээ тал руу нь чиглүүлж тодорхой ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байна.

1.1.3 Халамжийн үйлчилгээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй харьцуулан тооцож олгох бодлого байхгүй байна

Монгол Улсын Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг сард 2017 онд 240.0 мянга, 2019 онд 320.0 мянган, 2020 онд 420.0 мянган төгрөг байхаар заасан байна.

График №1



Засгийн газрын 2018 оны 17 дугаар тогтоолоор Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр 155.0 мянган төгрөг байсан ба 2020 оны 25 дугаар тогтоолоор 188.0 мянган төгрөг болж 17.5 хувиар буюу 33.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 2020 онд 2017 онтой харьцуулахад 75 хувиар буюу 180.0 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнээс үзэхэд халамжийн үйлчилгээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний өсөлттэй уялдуулаагүй байна.

Засгийн газраас Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэд зэрэг орлого багатай, эрсдэлд өртөмхий хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах, орлогыг нэмэгдүүлэх дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Монгол Улсын 0-18 насны 1.2 сая хүүхэд бүрд олгох хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс сар бүр 100.0 мянган төгрөг болгож нэмэгдүүлсэн
- Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэрийг 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс сар бүр 100.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн
- Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд олгож байгаа хүнсний эрхийн бичгийн үнийн дүнг 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс мөн оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд нэг хүүхдэд 16.0 мянган төгрөг, насанд хүрсэн нэг гишүүнд 32.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлжээ.

Нийгмийн халамжийн сангийн 10 төрөлд хамаарах 72 үйлчилгээний зөвхөн нэг үйлчилгээ болох гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү байхаар заасан байна.

Бусад халамжийн үйлчилгээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдаагүй, халамжийн сангаас олгож байгаа мөнгөн дүн нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс харьцангуй бага байна. Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа мөнгө нь нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилготой олгодогтой холбоотой байна.

1.2 Халамжийн үйлчилгээнд шаардлагатай орон нутгийн төсвийг үндэслэлтэй төлөвлөсөн байна

1.2.1 Халамжийн сангийн арилжааны банкн дахь дансны үлдэгдэл, хүүгийн орлогыг төвлөрүүлсэн байна

Тус аймгийн Халамжийн сангийн арилжааны банкин дахь улсын болон орон нутгийн төсвийн харилцах дансны 2020 оны жилийн эцсийн үлдэгдлээс нийтдээ 114.6 сая төгрөгийг ХХҮЕГ-ын төрийн сан дахь дансанд төвлөрүүлсэн байна. Үүнд: алдар цолтны данснаас 0.3 сая, алдарт эхийн данснаас 54.9 сая, цалинтай ээжийн данснаас 10.1 сая, насны хишиг данснаас 1.9 сая, халамжийн тэтгэмжийн данснаас 1.7 сая, амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжийн данснаас 2.1 сая, ахмадын хөнгөлөлт данснаас 0.9 сая, ХБИргэний хөнгөлөлтийн данснаас 0.1 сая, өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмжийн данснаас 6.1 сая, ихэр хүүхдийн тэтгэмжийн данснаас 10.0 сая, онцгой тохиолдлын тэтгэмжийн данснаас 26.1 сая төгрөг тус тус төвлөрүүлжээ.

Улсын болон орон нутгийн халамжийн сангийн төсвийн харилцах дансны жилийн эцсийн үлдэгдлээс 2021 онд нийтдээ 24.3 сая төгрөг төвлөрүүлснээс халамжийн тэтгэмжийн данснаас 16.7 сая, хүнс тэжээлийн дэмжлэг туслалцааны данснаас 4.6 сая, амжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжийн данснаас 0.2 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Халамжийн сангийн данснаас төвлөрүүлсэн мөнгөний хэмжээ 2021 онд өмнөх оноос буурсан нь ахмад, ХБИргэн, хүнс тэжээлийн дэмжлэг туслалцааны үйлчилгээнээс бусад халамжийн үйлчилгээнүүд “И-халамж” системээр Сангийн яамнаас шууд олгогддог болсонтой холбоотой байна.

Аймгийн Халамжийн сангийн арилжааны банкн дахь дансны үлдэгдэл 2020 оны эхэнд 207.1 сая төгрөг ба оны эцэст 2.5 сая төгрөг болж оны эхнээс 204.6 сая төгрөгөөр буурсан байна. 2021 оны жилийн эцэст үлдэгдэлгүй байна.

Хүснэгт №3	2020 он		2021 он		/сая.төг/ Өсөлт +), Бууралт (-))
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
Арилжааны банканд байгаа бэлэн мөнгө	207.1	2.5	2.5	0	207.1
Дүн	207.1	2.5	2.5	0	207.1

Эх сурвалж: /Аймгийн ХХҮГазрын санхүүгийн тайлангаас/

Баян-Өлгий аймгийн НХСан нь 2017 онд төсөв дутуу батлагдсанаас үүссэн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтийн 1,700.0 сая төгрөгийн өглөгтэй байсныг Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 471 дүгээр тогтоолоор барагдуулахаар шийдвэрлэсний дагуу санхүүжилт нь 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр арилжааны банкин дахь дансанд орсон байна.

Үүнээс тухайн онд багтаан авч чадаагүй 8,184 иргэний 207.1 сая төгрөгийг Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам"-ын 4.4-т "Тэтгэвэр, тэтгэмжийг тухайн онд авч чадаагүй бол дараагийн санхүүгийн жилд нөхөн олгоно" гэсний дагуу 2020 оны 1-2 сард нөхөж олгосон байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Сангийн яам, арилжааны банктai гуравласан гэрээ байгуулж, халамжийн сангийн арилжааны банкин дахь дансанд 0.3 хувийн хүү тооцож олгосон байна.

Аймгийн Халамжийн сангийн арилжааны банкин дахь дансанд 2020-2021 онд нийт 9.9 сая төгрөгийг ХХҮЕГ-ын Төрийн сан дахь 10090000901 тоот хүүгийн орлого харилцахын дансанд Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалтын дагуу жилийн эцэст бүрэн төвлөрүүлсэн байна.

Халамжийн сангаас үзүүлэх үйлчилгээнүүд цахимд шилжсэнээр 2022 оноос арилжааны банканд байршиж байсан бүх данс хаагдаж, Халамжийн сангаас үзүүлэх үйлчилгээний мөнгийг Сангийн яам, Монгол банкаар дамжуулан иргэдийн дансанд шууд шилжүүлдэг болсон байна.

1.2.2 Халамжийн үйлчилгээнд шаардагдах хөрөнгийг үндэслэлтэй төлөвлөсөн байна

Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамжийн сангийн төсвийн төслийг боловсруулахдаа сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн дунджаар тооцоо судалгааг үндэслэн хийж Төсвийн тухай хуулийн 8.3.4-т "санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын баталсан жилийн төсвийн хязгаарыг төсвийн удирдамжийн хамт жил бүрийн 7 дугаар сарын 5-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх" гэсний дагуу хуулийн хугацаанд нь батлагдсан маягтын дагуу гаргаж, хүргүүлж ажилласан байна. Төсвийн төсөөллийн санал болон батлагдсан төсвийг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт №4		/сая.төг/						
Д/д	Он	Төсвийн төсөл		Батлагдсан төсөв		Зөрүү		Хувь
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	
1	2020 он	68,227	25,364.3	61,042	20,225.6	7,185	5,138.7	89.5
2	2021 он	65,923	23,047.4	58,992	23,045.7	6,931	1.7	89.5
3	2022 он	40,935	11,575.6	40,935	11,734.4	0	(158.8)	100.0

Эх сурвалж: /Аймгийн ХХҮГ-ын тайлангаас/

Нийгмийн халамжийн сангаас халамж авагчдын тоо болон төсвийг тооцоо судалгааны үндсэн дээр жил болгон бууруулж төлөвлөж ирсэн байна.

Нийгмийн халамжийн сангийн төсвийг төлөвлөхөд ирэх онд хэдэн хүн хөдөлмөрийн чадвараа алдах, хэдэн хүн жирэмслэх, хэдэн хүн ахмадын амралт сувилалд амрах, нийслэл рүү эмчилгээнд явах нь тодорхойгүй учраас халамжийн үйлчилгээнд хамрагдах хүний тоог бодиттойгоор төсөвлөхөд хүндрэлтэй байдаг байна.

Аймгийн Халамжийн сангийн 2020-2021 онд хүргүүлсэн төсвийн төсөөллийн 89.5 хувь нь батлагдсан байна. 2022 онд цахим системээр Сангийн яамнаас шууд олгогдож байгаа тул хагас жилийн байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аудитын явцад хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс орон тооны төлөвлөлт дутуу байгаатай холбоотой иргэдэд хүрч ажиллаж чадахгүй байгаа талаар гомдол саналууд гарч байсан тул орон тооны төлөвлөлтийг тодруулж үзлээ.

Тус аймгийн сум, багт нийтдээ 19 хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллаж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомж, төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг иргэд, байгууллага, ажил олгогчид хүргэх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, ажлын байрны сул орон тооны мэдээллийг холбогдох байгууллагаас сар бүр авч мэдээллийн баазад оруулах, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх-иргэнийг тодорхойлох, халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдах иргэдийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, программд бүртгэж, баталгаажуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэдэг байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5-д “Сум, хорооны нийгмийн ажилтны орон тооны жишиг нормативыг тухайн засаг захиргааны нэгжийн хүн ам, нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний тоог харгалзан нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасны дагуу Засгийн газрын 2010 оны 334 дүгээр тогтоолоор “Нийгмийн үйлчилгээний жишиг норматив” баталсан байна.

Тогтоолын 4.2-т нийгмийн халамжийн үйлчилгээг сум, хороонд хүргэх нийгмийн ажилтны тоо тухайн сум, хорооны хүн амын тооноос хамаарч дараахь байдлаар тогтоосон байна. Хүснэгт №

Сумын хүн амын тоо	Нийгмийн ажилтны тоо
1000-3000	1
3000-аас дээш	1+нэмэгдэж байгаа 3000 хүн ам тутамд 1 нийгмийн ажилтан

Эх сурвалж: /Засгийн газрын 2010 оны 334 дүгээр тогтоол/

Баян-Өлгий аймгийн хүн амын тоо 2010 онд 85,359 байсан ба 2021 оны байдлаар 27,477 хүн нэмэгдсэн байна.

2021 оны байдлаарх хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд ноогдож байгаа хүн амын тоог харьцуулж хүснэгтээр үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт №5

/сая.төг/

№	Сумын нэр	Хүн амын тоо	Ажиллаж байгаа Нийгмийн ажилтан	Ажиллах ёстой Нийгмийн ажилтаны тоо	Зөрүү
1	Алтай	4309	1	2	-1
2	Алтанцөгц	2893	1	1	
3	Баяннуур	4911	1	2	-1
4	Бугат	3965	1	1	
5	Булган	5134	1	2	-1
6	Буянт	2830	1	1	
7	Дэлүүн	7548	1	2.5	-2
8	Ногооннуур	6517	1	2	-1
9	Толбо	4319	1	2	-1
10	Сагсай	5342	1	2	-1
11	Улаанхус	8839	1	3	-2
12	Цагааннуур	1668	1	1	
13	Цэнгэл	9798	1	3	-2
14	Өлгий сумын	44763	6	15	-9
	Нийт	112836	19	39.5	-20.5

Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан /www.1212.mn/ -гаас

Сум, багийн иргэдийн хүн амын тоо болон халамжийн үйлчилгээ авагчдын тоо харилцан адилгүй байна. Тухайлбал:

Алтай, Баяннуур, Булган, Ногооннуур, Толбо, Сагсай зэрэг сумуудад 2, Дэлүүн, Улаанхус, Цэнгэл зэрэг сумуудад 3, Өлгий сумд 15 нийгмийн ажилтантай байх ёстой боловч дээрх сумуудад 2-3 нийгмийн ажилтны ажлыг нэг хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцан ажилладаг байна.

Үүнээс үзэхэд нийгмийн ажилтнууд нь айл, өрхөд очиж нөхцөл байдлын үнэлгээ хийх, халамж шаардлагатай иргэнд зөвлөгөө мэдээлэл өгөх, мэдээлэл дутмагаас халамжийн болон нийгмийн бусад үйлчилгээнд хамрагдаж чадаагүй иргэдийг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах зэргээр нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээг хүргэхэд хүндрэлтэй байгаа нь аудитын явцад ажиглагдлаа.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс бусад хөдөлмөр эрхлэлт болон халамжийн үйлчилгээг бүрэн хүргэхийн тулд харилцаа холбооны зардал, асаргааны тэтгэмжийг тухайн өрхөд очиж шалгах бензин шатахууны зардал зэргийг хувиасаа гарган ажилладаг нь хөдөлмөр эрхлэлт болон халамжийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэж чадахгүй байх магадлалтай байна.

1.2.3 Орон нутгийн төсвөөс халамжийн үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг төлөвлөснөөс 1-3 дахин бууруулж баталсан байна

Халамжийн сангийн орон нутгийн төсвийн 2020-2022 оны төсвийн төсөөллийг бодит тооцооллыг үндэслэн Төсвийн тухай хуулийн 8.3.4-т заасны дагуу хуулийн хугацаанд нь аймгийн ТЭЗ-д батлагдсан маягтын дагуу гаргаж хүргүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн төсөөллийн санал болон батлагдсан төсвийг хүснэгтээр харуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №6		Төсвийн санал		/сая.төг/ Батлагдсан төсөв		Хувь
Он	Халамжийн үйлчилгээний төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	
2020	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмж	455.0	546.0	100.0	150.6	27.6
	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	1,006.0	165.8	211.0	24.4	14.7
	Дүн	1,461	711.8	311,0	175.0	24.6
2021	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмж	265.0	318.0	80.0	102.0	32.1
	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	1,006.0	165.8	558.0	66.4	40.0
	Дүн	1,271	483.8	638	168.4	34.8
2022	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмж	120.0	144.0	140.0	160.0	111.1
	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	640.0	159.4	555.0	39.8	25.0
	Дүн	760	303.4	695	199.8	65.8

Эх сурвалжийг: /Аймгийн ХХҮ-ын тайлангаас/

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжийн төслийг 2022 онд 2020 оноос 73.6 хувиар буруулан төсөвлөсөн байна. 2020 онд 26.4 сая, 2021 онд 2.4 сая төгрөгийг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсвийн төсөөллийг судалгаа тооцоог үндэслэн хийж хүргүүлдэг боловч 2020-2022 онд 1-3 дахин буюу 60- 85.3 хувиар бууруулж баталсан байна.

Энэ нь Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг иргэдэд төлөвлөсөн хэмжээгээр, хүртээмжтэй хүргэхэд хангалтгүй төсөв болсон байна.

БҮЛЭГ 2. ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮР НӨЛӨӨТЭЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА

2.1. Халамжийн үйлчилгээнд зорилтот эмзэг бүлгийн иргэдийг хамруулан ажилласан байна

2.1.1 Халамжийн үйлчилгээ зорилтот эмзэг бүлгийн иргэдэд хүрч байна

Халамжийн үйлчилгээ нь эмзэг бүлгийн иргэдэд бүрэн хүрч чадахгүй байгаа нь зорилтот бүлгийн иргэдийг тодорхойлж байгаа шалгуур оновчтой бус байгаагаас судалгаа бодитой гарахгүй байгааатай холбоотой юм. Дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай байгаа эмзэг бүлгийн иргэдийг тодорхойлох шалгуур судалгаа нь 2017 онд батлагдсан бөгөөд эдийн засаг, нийгмийн хүчин зүйлтэй уялдуулж шинэчлэн тогтоогоогүй байна.

Хэдийгээр дээрх журмыг шинэчлэн тогтоогоогүй боловч 2020 оноос эхлэн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор зарим төрлийн үйлчилгээг иргэний арилжааны банкин дахь нэрийн дансанд шууд шилжүүлэх, данс нээлгэх, карт олгох ажлыг зохион байгуулж ажилласан байна.

Аудитын явцад аймгийн төвийн Өлгий сумын Засаг даргын тамгын газраас сумын 13 багийн хэмжээнд нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж чадаагүй 349 өрх байгаа талаар судалгаа ирүүлсэн бөгөөд энэ нь сумын нийт өрхийн 3.7 хувийг эзэлж байна. Энэ нь Эмнэлэг хөдөлмөр магдлах комиссоор хөдөлмөр чадвар алдалтаа тогтоолгож халамжийн тэтгэвэр авч байгаад Эмнэлэг, хөдөлмөр магадлах комисс /ЭХМК/-оор дахиж сунгалт хийлгэж чадаагүйн улмаас халамжийн тэтгэвэр нь зогссон, хүнсний эрхийн бичгийн тусламж дэмжлэг авч байгаа өрхийн амьжиргаа дээшилсэн нь тухайн сум багийн Амьжиргаа дэмжих зөвлөлийн гишүүдийн шийдвэрээр тогтоогдсон тул үйлчилгээ нь зогссон, өрхийн амжиргааны түвшин тогтоох судалгаагаар босго оноо нь 320-оос дээш оноотой өрхүүд байна.

Аудитын явцад 588 иргэдээс авсан санал асуулгын дүнгээс үзэхэд “Нийгмийн халамжийн үйлчилгээ эмзэг бүлгийн иргэдэд хүрж чадаж байна уу” гэсэн асуултад 110 хүн буюу 26.6 хувь буюу бага хувь нь “үгүй” гэж хариулсан нь халамжийн үйлчилгээг зорилтот эмзэг бүлгийн иргэдэд бүрэн хүрч байна гэж үзэхээр байна.

2.1.2 Судалгаагаар иргэдийн 80.3 хувь нь халамжийг бэлэн мөнгөөр олгох нь үр дүнтэй байна үзсэн байна

Нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээнээс олон нийтийн оролцоог түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон хүнсний эрхийн бичгээс бусад 70 төрлийн үйлчилгээ одоогийн хууль тогтоомжийн хүрээнд бэлэн мөнгөний хөтөлбөрүүд байна. Үүнээс үзэхэд дийлэнх хувийг бэлэн мөнгө эзэлж, өрх иргэнийг чадавхжуулах, бие даан амьдрах чадварыг нэмэгдүүлэх үйлчилгээ хангалтгүй байна гэж үзэхээр байна. Тухайлбал:

Халамжийн сангаас олгож байгаа үйлчилгээнүүдийн олгож байгаа хэлбэрийг 2020-2022 оны байдлаар судалж үзэхэд 89.3 хувь нь бэлэн мөнгө хэлбэрээр, 10.7 хувь нь үйлчилгээний хэлбэрээр иргэдэд олгогдож ирсэн байна. Тухайлбал: 2020 онд 83.1 хувь нь бэлэн мөнгөөр, 16.9 хувь нь үйлчилгээний хэлбэрээр, 2021 онд 91.5 хувь нь бэлэн мөнгөөр, 8.5 хувь нь үйлчилгээний хэлбэрээр, 2022 онд 93.4 хувь нь бэлэн мөнгөөр, 6.6 хувь нь үйлчилгээний хэлбэрээр олгогдсон байна.

Хүснэгт №7

Үзүүлэлт	2020 он		Хувь	2021 он		Хувь	2022 он		Хувь
	Хүний тоо	Мөнгөн дүн		Хүний тоо	Мөнгөн дүн		Хүний тоо	Мөнгөн дүн	
Бэлэн мөнгөөр	46,474	16,945.5	83.1	40,721	21,255.4	91.5	29,994	11,048.3	93.4
Үйлчилгээ хэлбэрээр	14,862	3,458.3	16.9	15,055	1,985.2	8.5	10,675	779.8	6.6
Дүн	61,336	20,403.8	100	55,776	23,240.6	100	40,669	11,828.1	100

сая.төг

Эх сурвалж: /аймгийн ХХҮГ-аас /

Аудитын явцад иргэдээс авсан санал асуулгын дүнгээс үзэхэд “Нийгмийн халамжийн үйлчилгээг бэлэн мөнгөөр үзүүлж байгаа нь зөв үү” гэсэн асуултад 472 хүн буюу 80.3 хувь нь “тийм” гэж хариулсан нь халамжийн үйлчилгээ авдаг иргэд нь эмзэг бүлгийн иргэд байдгаас өдөр тутмын хэрэгцээгээ хангахын тулд үйлчилгээг бэлэн мөнгөөр авах сонирхолтой байгааг харуулж байна

Үүнээс үзэхэд эмзэг бүлгийн зорилтот өрх, иргэдийн бие даан амьдрах чадварыг нь дээшлүүлэх, зан үйл, хандлагыг өөрчлөх, амьжиргааг дэмжих үйлчилгээ бий болгох хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн бодлоготой уялдуулах замаар халамж хүртэгчийг ажилтай, орлоготой болгоход анхаарах шаардлагатай байна.

Нийгмийн халамжийн зардал өндөр байгаа боловч амьжиргааны түвшин доогуур зорилтот бүлгийн хүн амьд очих халамжийн тэтгэмж, тусламжийн хэмжээ бага байна. Аудитын явцад аймгийн төвийн халамжийн үйлчилгээ авч байгаа зарим өрхүүдэд очиж иргэдтэй уулзахад одоогийн өгч буй халамжийн үйлчилгээ нь өргөн хэрэглээний барааны үнэ нэмэгдсэнтэй холбоотой иргэдийн өдөр тутмын хэрэгцээг хангахад хүрэлцэхгүй болсон байна.

2.1.3 “www.ehalamj.mn” нэгдсэн системийн халамжийн цахим мэдээлэл нь бусад төрийн байгууллагуудын мэдээллийн баазтай уялдаатай байна

Халамжийн нэгдсэн систем www.ehalamj.mn нь 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдөр нээлтээ хийж, 2021 онд нийгмийн халамжийн 11 төрлийн үйлчилгээг www.ehalamj.mn-д системд нэвтрүүлсэн байна.

Халамжийн сангийн цахим сан дахь мэдээлэл нь Улсын бүртгэлийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Эрүүл мэндийн яамны мэдээллийн баазтай уялдаа холбоотой байна.

<https://inspector.ehalamj.mn/> веб сайтад аймаг, сум хариуцсан мэргэжилтний эрхээр орж, халамжийн үйлчилгээг үзүүлдэг. Нийгмийн халамжийн үйлчилгээний нэгдсэн /WAIS/ системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, шинэчлэлт өөрчлөлтийг тухай бүр тохиргоонуудыг хийж, программын өдөр тутмын хэвийн ажиллагааг ханган ажилласан байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн өрхийн мэдээллийн нэгдсэн санг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, өрх иргэний мэдээллийг тухай бүр тулган шалгаж баталгаажуулан өрхийн мэдээллийн сангийн найдвартай, үнэн зөв, бодитой байдлыг хангасан байна.

Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Ерөнхий газрын даргын 2017 оны 09 дүгээр сарын 22-ний өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан зааврын дагуу баталгаажуулалт хийх өрхийн жагсаалтыг сумдын мэргэжилтнүүдэд хүргүүлэн мэдээллийн зөрүүг тулгалт хийж, нийт 477 өрхийн зөрүүтэй мэдээллийг баталгаажуулан оноог шинээр бодуулан ажиллажээ.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ нь 2021 оны 7 дугаар сараас цахим системд шилжсэн бөгөөд цахим мэдээллийн сан нь төрийн байгууллагын нэгдсэн цахим мэдээллийн системд холбогдоогүй байна.

Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж буй хүнсний эрхийн бичиг программ heb2017.hudulmur-halamj.gov.mn, www.ehalamj.mn www.lims.gov.mn системийн программууд хоорондоо уялдаа холбоогүй байна. Цаашид хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг энэ программтай уялдуулах шаардлагатай байна.

Нийгмийн халамжийн төвлөрсөн мэдээллийн сан бүрдэж, улсын хэмжээнд нэвтрүүлсэн системийн ашиглалт сайжирч алдаа гарах нь багасаж, программд гарсан санал, гомдлыг дээд байгууллагад хүргэж алдааг арилгах тал дээр санаачилгатай ажилласан байна. Үүний үр дүнд иргэд халамжийн аливаа нэгэн үйлчилгээнд давхар хамрагдах боломжгүй болж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний программаас бусад программ нь төрийн байгууллагын нэгдсэн цахим мэдээллийн систем, мэдээллийн сангийн баазтай бүрэн уялдаа холбоотой болсон байна.

2.1.4 Мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан байна

Халамжийн сангийн мэдээллийг жил бүр Шилэн дансны цахим систем болон веб хуудсанд иргэд олон нийтэд нээлттэй мэдээлж, мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг хангуулж ажилласан байна.

Мөн хуулийн хүрээнд салбарын баримтлах бодлого, журам, хөтөлбөрүүдийн өөрчлөлт, байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг цахим хуудсаар болон олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сонин сэтгүүл, гарын авлага, танилцуулга хэлбэрээр хэвлүүлж, мэдээллийг иргэд олон нийтэд шуурхай хүргэх ажлыг зохион байгуулсан байна.

Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн ажлын хүрээнд тус газар нь “Иргэдээ сонсох утас”, www.bayan-olgi.hudulmur-halamj.gov.mn цахим хуудсыг тогтмол ажиллуулан, төрийн үйлчилгээ болон албан хаагчдын харилцаа хандлагын талаар иргэдээс ирсэн санал гомдлыг хүлээн авах үйлчилгээг нэвтрүүлэн ажилласан байна.

Халамжийн үйлчилгээг ард иргэдэд ил тод хүргэх зорилгоор www.ehalamj.mn, www.e-mongolia цахим системээр онлайнаар ард иргэдэд үнэ төлбөргүй, түргэн, хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлдэг байна. Мөн Хөдөлмөр халамжийн тайланг www.hudulmur-halamj.gov.mn цахим хуудсанд тухай бүр байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан байна.

2.2. Халамжийн үйлчилгээг хууль журмын дагуу үзүүлсэн байна

2.2.1 Амьжиргаа дэмжих зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлээгүй байна

Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д заасны дагуу сум, багуудад амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл ажиллуулсан байна. Зөвлөлийг

сум, хорооны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж нийгмийн ажилтан 1, төрийн байгууллагын төлөөлөл 2, иргэний төлөөлөл 2, төрийн бус байгууллагын төлөөлөл 2, нийт 7 хүний бүрэлдэхүүнээр байгуулан ажиллуулсан байна.

Алтай, Баяннуур сумуудын АДЗ-ийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчид хэлэлцэж баталсан талаар шийдвэр байхгүй байна.

Зөвлөлийн бүрэлдэхүүнээс ТББ-ын болон иргэний төлөөлөлийг хуульд заасны дагуу 2 жил тутамд өөрчлөлт оруулж ажилласан байна. Дэлүүн, Ногооннуур сумуудын АДЗ-ийн ТББ-ын болон иргэний төлөөллийг өөрчилж батлах хугацаа болсон ч өөрчлөлт оруулаагүй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 27.8-д заасны дагуу “2000-аас дээш хүн амтай баг, тосгонд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр Зөвлөл ажиллуулж болно” гэж заасан ба Өлгий сумаас бусад сумуудад 2000-аас дээш хүн амтай баг байхгүй байна.

Хүснэгт №8

Сум	Багийн тоо	Багийн хүн амын дундаж тоо	Багийн нийт хүн амын тоо	АДЗ-ийн тоо	АДЗ-ийн гишүүний тоо
Алтай	5	400-1068	4342	1	7
Алтанцөгц	4	608-897	2887	1	7
Баяннуур	5	923-1029	4971	1	7
Бугат	5	702-920	4021	1	7
Булган	7	368-1016	5163	1	7
Буянт	4	684-757	2847	1	7
Дэлүүн	12	434-1300	7613	1	7
Ногооннуур	11	301-1663	8254	2	14
Өлгий	13	578-3941	39711	13	91
Сагсай	7	514-1586	5405	1	7
Толбо	6	443-1325	4364	1	7
Улаанхус	11	511-1127	8922	1	7
Цэнгэл	9	614-1620	9876	1	7
Нийт	99	368-3941	108376	26	182

Эх сурвалж: Аудитын судалгаа

Тус аймгийн 13 сумын 99 багт 26 амьжиргааг дэмжих зөвлөл ажилладаг байна. Өлгий сумын 13 баг болон 12 суманд тус бүр нэг, Ногооннуур сумын 9 дүгээр баг буюу Цагааннуур тосгонд 1 АДЗ ажиллаж байна.

Амьжиргааг дэмжих зөвлөлүүд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2012 оны 7 дугаар сарын 09-ны өдрийн А/89 тоот тушаалаар баталсан “Амьжиргааг дэмжих зөвлөлийн дүрэм”-ийг баримтлан ажилласан боловч хурлын ирц, бүртгэл, гишүүдийн ажил үүргийн хуваарь, үйлчилгээнд хамрагдсан иргэн, өрхөд эргэн хяналт тавьсан талаар холбогдох ажлын баримтууд байхгүй байна.

Энэхүү дүрмийн 1.2-т “Зөвлөл нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 12.1.4-12.1.5-д заасан тэтгэвэр, 13.2, 13.5.1-13.5.4, 13.5.6-13.5.8-д заасан тэтгэмж, 18.1-д заасан үйлчилгээ, ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.3-т заасан мөнгөн тусламжид хамрагдах хүсэлт гаргасан өрх, иргэний баримт бичиг, амьдралын нөхцөлийг нь судлан үзэж, тэдгээрийг холбогдох нийгмийн халамжийн үйл ажиллагаанд хамруулах эсэхийг хэлэлцэн шийдвэрлэнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллажээ.

Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.14-т “амьжиргааг дэмжих зөвлөл нь энэхүү журмын 2.13-т заасан байнгын асаргаа шаардлагатай иргэний нөхцөл байдлыг судлаад тэтгэмжид хамруулах эсэх талаар шийдвэр гаргана” гэсний дагуу байнгын асаргаа шаардлагатай 16 нас хүртэл насны хүүхэд, түүнээс дээш насны иргэнд асаргаа шаардлагатай талаар Эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтыг амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж ирсэн байна.

Тогтоолын 4.16-д заасны дагуу гэр оронгүй тэнэмэл өрх, иргэнд тэтгэмж олгохдоо Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.8-д заасан үйлчилгээнд хамрагдсан бүртгэл, бие даан амьдрах чадвартай, орон гэр зайлшгүй шаардлагатайг нотолсон нийгмийн ажилтны нөхцөл байдлын үнэлгээ, амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэрийг үндэслэнэ гэснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.10-т “Зөвлөлийн гишүүнд болон сум, хорооны нийгмийн ажилтанд ажлын оролцоо, идэвх чармайлтыг харгалзан улиралд нэг удаа урамшуулал олгох бөгөөд уг урамшууллын хэмжээ, олгох журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэсний дагуу 2020-2021 онд улирал тутам 43,800 төгрөг, 2022 онд улиралд 37,200 төгрөгөөр тооцож урамшуулал олгосон байна.

Түүврээр шалгасан байнгын асаргаа шаардлагатай иргэний хувийн хэргүүдээс ковидын цар тахлын үетэй давхацсан 2020, 2021 онууд болон 2022 оны зарим хувийн хэргүүдэд байнгын асаргаа шаардлагатай талаар Эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтыг амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлээгүй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6-д “Зөвлөлийн үйл ажиллагаанд суманд иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, хороонд иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчид хяналт тавьж ажиллана” гэсэн боловч 2020-2022 онуудад хяналт хэрэгжээгүй байна.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь сум, багуудын АДЗ-үүдийн үйл ажиллаатай танилцаагүй, хяналтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ХХҮГ-т сум, багуудын АДЗ-үүдийн үйл ажиллаатай танилцаж, хяналтыг хэрэгжүүлж, ажлын баримт, тайлан судалгаа гаргаж ажиллах талаар зөвлөмж өгөв.

Сум, багуудын амьжиргааг дэмжих зөвлөлүүдэд хурлын тэмдэглэл, ажлын тайлан мэдээ, судалгааг архивлаж хадгалах, баримт бичгийн эмх цэгцийг сайжруулах, ирцийн бүртгэл хөтлөх, АДЗ-ийн төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

2.2.2 Хууль, журамд заасан шалгуур хангаагүй 126 иргэнд халамжийн тэтгэвэр олгосон байна

Нийгмийн халамжийн тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар халамжийн үйл ажиллагаа нь нийгмийн халамжийн тэтгэвэр, нийгмийн халамжийн тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ гэсэн төрөлтэй.

Дээрх үйлчилгээнүүдийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.8, Ахмад настны тухай хуулийн 3.1, 3.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 37 дугаар зүйлийн 37.2.2, Гэр бүлийн тухай хуулийн 59.4, Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 4.8, 4.9-д заасан шалгуураар Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 27 дугаар тогтоол,

2020 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн 167 дугаар тогтоолоор баталсан хэмжээгээр олгохоор заажээ.

Нийгмийн халамжийн тэтгэврийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан иргэдэд холбогдох хууль, журамд заасан нэмэлт шалгуур хангасан иргэдэд олгосон байна.

Нийгмийн халамжийн тэтгэврийг 2020-2022 онд авч байсан нийт иргэнээс 25.6 хувийг түүвэрт хамруулж шалгасан. Үүнд:

60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй 82 иргэнээс 43 иргэн буюу 52%-ийг, 16 насанд хүрсэн 4 одой иргэний 2-ыг буюу 50%-ийг, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд бүрсэн хөгжлийн бэрхшээлтэй 2343 иргэнээс 558 иргэнийг буюу 24%-ийг, 18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг 2 иргэнээс 1 иргэнийг буюу 50%-ийг тус тус түүвэрт хамруулсан. /Хүснэгт №.../

Хүснэгт №9 Халамжийн тэтгэвэрт хийсэн түүвэр шалгалт

Нийгмийн халамжийн тэтгэвэр	Халамжийн тэтгэвэр авсан хүний тоо	Түүвэрт хамруулсан		Шалгуур хангаагүй хүний тоо
		Хүний тоо	Эзлэх хувь	
60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй	82	43	52%	
16 насанд хүрсэн одой иргэн	4	2	55%	
Хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн ХБИ	2343	558	24%	108
Тэжээгч нь нас барсан гэр бүлийн 18 хүртэлх насны хүүхэд	475	141	30%	18
18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг	1	1	100%	
Бүгд	2905	745	25.6%	126

Эх сурвалж: Аудиторын судалгаа

Түүвэрт хамруулж шалгасан сумууд болох Өлгий, Алтай, Дэлүүн, Улаанхус, Цэнгэл, Ногооннуур сумууд дээрх хууль, журамд заасан шалгуур хангасан иргэдэд халамжийн тэтгэврийг олгосон байна.

Булган сумын халамжийн тэтгэврийн сангаас 2020-2021 онд 125, Буянт сумын халамжийн тэтгэврийн сангаас 2021 онд 1, нийт 126 иргэнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актгүй буюу шалгуур хангаагүй иргэдэд халамжийн тэтгэвэр олгосон тул зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөгдөж, төлбөрийн акт тогтоов.

Байнгын асаргаа шаардлагатай 16 нас хүртэл, түүнээс дээш насны иргэнд олгох тэтгэмжүүдийг шалгуур хангасан иргэдэд олгож ирсэн байна.

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2018 оны хамтарсан А/69/48 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.1-д “байнгын асаргаанд байх шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг тодорхойлох, асаргаанд байх хугацааг тогтоох, сунгах, цуцлах асуудлыг шийдвэрлэхэд энэхүү зааврыг баримтлана”, 1.4-т “байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртлэх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн (цаашид өвчин гэмтлийн жагсаалт гэх)” ба “ байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг

үнэлэх шалгуур, үзүүлэлт (цаашид шалгуур, үзүүлэлт гэх)-ийг үндэслэн асаргааг тогтооно” гэж заасан.

Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг үнэлэх шалгуур үзүүлэлт, оюуны хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн хүнд хэлбэрийн эмгэгтэй хүүхэд ба иргэнийг үнэлэх шалгуур, үзүүлэлтийг тус тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан байна.

Тус журмын 3.8-д заасны дагуу эмнэлгийн комисс нь өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийг үндэслэн байнгын асаргаа тогтоох эсэхийг шийдвэрлэж ирсэн байна.

Тус журмын 5.2-т заасны дагуу байнгын асаргаа тогтоосон болон сунгасан тухай шийдвэрийг Эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан маягтан дээр холбогдох эмч мэргэжилтнүүд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Засгийн газрын 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 2.13-т заасан байнгын асаргаа шаардлагатай тухай эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт байгаа эсэхийг жил жилээр, сунгуулсан сар өдрөөр, аймгийн Нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын хяналтын комиссын тодорхойлолтын сар өдрийг олголт хийж эхэлсэн өдөртэй, e-halamj программын олголттой, мөн байнгын асаргаа шаардлагатай иргэний тодорхойлолт дахь өвчтөний өвчний олон улсын кодыг түүврээр Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/69/48 дугаар хамтарсан тушаалын 1, 2 дугаар хавсралттай тулгаж шалгаж үзэхэд зөрчил дутагдал гараагүй.

Тэтгэмжийн олголтыг e-halamj системд мэргэжилтэн нарын нэвтрэх кодоор орж, хүн тус бүрээр шалгаж үзэхэд тэтгэмжийг буруу зөрүүтэй олгосон, асаргаа шаардлагатай тухай эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтын он, сар, өдрөөр зөрж тэтгэмж олгогдсон зөрчил дутагдал гараагүй болно.

Эмнэлэгийн хяналтанд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний тэтгэмж, Ахмад настныг асарч буй иргэний тэтгэмж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэний тэтгэмж, Бүтэн өнчин хүүхдийг асарч байгаа иргэний тэтгэмж, Насны хишиг, Өрх толгойлсон эцэх, эхийн тэтгэмж, Алдар цолтон, Жирэмсэн эхийн тэтгэмж зэрэг 9 үйлчилгээг шалгахад халамжийн хууль, журамд заасан шалгуурд нийцэхгүй, хөдөлмөр эрхэлдэг иргэнд олгосон зөрчил дутагдал гараагүй.

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний талаар:

Тус аймагт 2020-2022 онд Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний хүрээнд дараах үйлчилгээнүүдийг зорилтод бүлэгт хүргүүлэн ажилласан байна. Үүнд:

- Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах үйлчилгээ
- Амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор сургалт зохион байгуулах үйлчилгээ
- Сэргээн засах үйлчилгээнд хамруулах үйлчилгээ
- Өдрийн үйлчилгээнд хамруулах үйлчилгээ

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 2020 оны А/16, 2021 оны А/01, 2022 оны А/06 дугаар тушаалаар аймгийн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулсан байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын баталсан “бүлгийн төсөл хэрэгжүүлэх удирдамж”-ыг үндэслэн гаргасан аймгийн ХХҮГ-ын даргын “Бүлгийн төсөл хэрэгжүүлэх” удирдамжын дагуу тухайн оны эхний улиралд багтаан Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай энэ хуулийн 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах ажлыг зохион байгуулсан байна.

2020-2022 онд олгосон бүлгийн төслийн задаргааг хүснэгтээр харуулав.

Хүснэгт №10														/сая.төг/	
Он	Ахмад настан		ХБИ		Өрх толгойлсон эцэг,эх		ХБ хүүхэдтэй иргэн		Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэн		Гэр оронгүй иргэн		ДҮН		
	Бүлгийн тоо	Мөнгө н дүн	Бүлгийн тоо	Мөнгө н дүн	Бүлгийн тоо	Мөнгө н дүн	Бүлгийн тоо	Мөнгө н дүн	Бүлгийн тоо	Мөнгөн дүн	Бүлгийн тоо	Мөнгө н дүн	Бүлгийн тоо	Мөнгө н дүн	
2020	4	5.5	7	9.9									11	15.4	
2021	3	4.0	4	5.9	5	6.9	1	1.4	1	1.4			14	19.6	
2022	2	4.0	3	6.0	2	4.0	1	2.0	1	2.0	1	2.0	10	20.0	
ДҮН	9	13.5	14	21.8	7	10.9	2	3.4	2	3.4	1	2.0	35	55.0	

Эх сурвалж: /Аймгийн ХХҮГ-аас/

Дээрх хүснэгтээс үзэхэд 2020 оноос 2022 оны эхний хагас жилийн байдлаар ахмад настны 9 бүлэгт 13.5 сая, хөгжлийн бэрхшээлтэй иргэний 14 бүлэгт 21.8 сая, өрх толгойлсон эцэг, эхийн 7 бүлэгт 10.9 сая, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй иргэний 2 бүлэгт 3.4 сая, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 2 иргэний бүлэгт 3.4 сая, гэр оронгүй иргэний 1 бүлэгт 2.0 сая, нийт 35 бүлэгт 55.0 сая төгрөг олгосон байна.

2020-2022 онд сэргээн засах үйлчилгээ, сургалт зохион байгуулах үйлчилгээ, өдрийн үйлчилгээ үзүүлэх төрийн бус байгууллагууд нь ХХҮЕГ-аас магадлан итгэмжлэлийн эрхийг авсан, аймгийн ХХҮГ-тай үйлчилгээг гүйцэтгүүлэх гэрээг зохих журмын дагуу байгуулсан эрх бүхий байгууллагууд үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнд:

- 2020 онд сэргээн засах үйлчилгээний хүрээнд “Шегиртай арасан” ХХК нь ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй 64 иргэнийг сэргээн засах үйлчилгээнд хамруулсан.
- “Аймгийн ахмадын хороо” ТББ, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхчүүдийн холбоо” зэрэг байгууллагууд амьдралын итгэл үнэмшил, бие даан амьдрах чадвар, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор 45 зорилтот бүлгийн иргэнд сургалт зохион байгуулсан.
- “Аймгийн ахмадын хороо” ТББ, “Аймгийн Улаан загалмайн холбоо” ТББ зэрэг байгууллагууд 2020-2021 онуудад нийтдээ 634 зорилтот бүлгийн иргэнийг өдрийн үйлчилгээнд хамруулсан байна.

Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт:

Ахмад настны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Ахмад настны амьжиргааг дэмжих, нийгмийн хамгааллыг сайжруулахад зориулан 2020 онд 10, 2021 онд 9, 2022 онд 7 төрлийн хөнгөлөлт үйлчилгээг ахмад настанд үзүүлсэн байна.

Ахмад настны хуулийн дагуу 2020-2022 оны эхний хагас жилийн байдлаар 2,797 ахмад настанд 482.4 сая төгрөгийн хөл, гарны протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл, тэргэнцэр, шүд /үнэт металлаар хийхээс бусад/-ний протез, ортопедийн хөнгөлөлт олгосон байна.

Ахмад настанд амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийн хөнгөлөлтийн талаар:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас ахмадын зориулалттай амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийг хөнгөлөлтийн итгэмжлэгдсэн эрх авсан “Шегиртэй Арасан” рашаан, сувилалын газарт 2020-2021 онд давхардсан тоогоор 2,476 ахмадын үйлчилгээнд 426.1 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Хүснэгт №11 Үзүүлэлт	2020 он		2021 он		2022 оны эхний хагас жил		/сая.төг/ 2020-2022 оны нийт дүн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шегиртэй Арасан сувилал	1136	227.2	957	198.9	383	74.5	2476	426.1
ДҮН	1136	227.2	957	198.9	383	74.5	2476	426.1

Эх сурвалж: /Аймгийн ХХҮГ-аас/

Аудитын явцад ахмад настан амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийн хөнгөлөлтийн материалыг түүврээр сонгон шалгаж үзэхэд Засгийн газрын 2016 оны 94 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан бичиг баримтыг бүрэн бүрдүүлж ажилласан байна.

Ахмад настан амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийн хөнгөлөлтийг олгох давтамж, мөнгөний хэмжээг мөрдөж байгаа талаар шалгахад 2020-2021 онд ахмад настанд өдрийн 20.0 мянган төгрөгөөр 10 хоногт 200.0 мянган төгрөг тооцож олгожээ. Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын 2017 оны А/115 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Амрах эрхийн бичгийн тасалбар”-ыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга нь гарын үсэг зурж олгосон байна.

Аудитын явцад 57 ахмад настанаас утсаар холбогдож хэвтсэн хоногийг тодруулж асуухад 1 хүн хэвтээгүй, 1 хүн 8 хоног хэвтсэн, үлдсэн хүмүүс 10 хоног хэвтсэн, зарим нь хэвтсэн хоногоо мартсан байна, хэвтэж эмчилгээ хийлгэсэн нь үнэн гэсэн хариу өгсөн. Аудитаар ахмад настан амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийн хөнгөлөлтийг олгосон санхүүгийн баримтыг бүрэн хамруулж шалгах боломжгүй түүврийн аргаар 10 хувийг хамруулан шалгасан болно.

2022 оноос сувилалд хэвтэх ахмадууд аймгийн Халамжийн сангаас тасалбараа авч, сувиллалаас гарсан өдөр бүртгүүлэх систем бий болгож бодит гүйцэтгэлээр олгосон байна.

Түлш худалдан авах мөнгөн түслэмжийн талаар:

Хүснэгт №12			/сая.төг/
Үйлчилгээний нэр	2020 он	2021 он	Нийт
ДОА-2022/32-ШТА-ГА			25

Аймгийн Халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө

Шифр		Олгосон хүний тоо	Олгосон мөнгөн дүн	Олгосон хүний тоо	Олголт хийгдсэн олгосон дүн	Олгосон хүний тоо	Олголт хийгдсэн олгосон дүн
5301	Тэжээн тэтгэх хүүхэдгүй ахмад настанд олгох түлшний үнийн хөнгөлөлт	51	7,1	74	7,1	125	14,3
5302	Тэжээн тэтгэгч нь дэмжлэг тусалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд олгох түлшний үнийн хөнгөлөлт	982	137,5	919	7,1	1,901	144,6
5303	Хүндэт донор ахмад настанд олгох түлшний үнийн хөнгөлөлт	5	0,7	12	7,1	17	7,8
5304	Тэжээн тэтгэх хүүхэдгүй ахмад настанд олгох орон сууцны хөлс	2	0,3	25	7,1	27	7,4
5305	Тэжээн тэтгэгч нь дэмжлэг тусалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд олгох орон сууцны хөлс	3	0,4	2	7,1	5	7,6
Нийт дүн		1043	146,0	1032	35,7	2075	181,7

Эх сурвалж: /Аймгийн ХХҮГ-аас/

Халамжийн сангаас 2020 онд 1,043 ахмадад 146.0 сая, 2021 онд 1,032 ахмадад 144.5 сая, нийт 2,075 ахмадад 290.5 сая төгрөгийн түлш худалдан авах мөнгөн тусламж олгосон байна. 2022 оны эхний 6 сарын байдлаар түлш худалдан авах мөнгөн тусламжийг нэг иргэнд олгожээ.

Үүнээс хүндэт донор ахмад настанд олгох түлшний үнийн хөнгөлөлт, тэжээн тэтгэх хүүхэдгүй ахмад настанд олгох орон сууцны хөлс, тэжээн тэтгэгч нь дэмжлэг тусалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд олгох орон сууцны хөлс зэрэгт давхардсан тоогоор 49 ахмад настанд түлшний үнийн хөнгөлөлт, орон сууцны хөлсийг зохих журмын дагуу олгосон байна.

2020-2021 онд тэжээн тэтгэх хүүхэдгүй ахмад настанд олгох түлшний үнийн хөнгөлөлтийг 125, тэжээн тэтгэгч нь дэмжлэг тусалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настанд олгох түлшний үнийн хөнгөлөлтийг 190, давхардсан тоогоор нийт 2026 ахмад настанд 158.9 сая төгрөг олгосон байна.

Өмнөх жилүүдэд Амьжиргааг дэмжих зөвлөлийн шийдвэрийг үндэслэн ахмад настануудыг хөнгөлөлтөд хамруулахдаа Ахмад настны тухай хуулийн 8.1.3-т “тэжээн тэтгэх хүүхэдгүй, эсхүл хууль ёсны тэжээн тэтгэгч нь дэмжлэг, тусалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон ахмад настан, хүндэт донор ахмад настанд орон сууцны хөлс төлөхөд, хэрэв нийтийн халаалтгүй сууц, гэрт амьдардаг бол түлш худалдан авахад зориулан жилд нэг удаа мөнгөн тусламж олгох” гэсэн заалтын дагуу амьдралын нөхцөл байдлыг нь харгалзахгүйгээр хавтгайруулан олгосон байх магадлалтай байна.

Аймгийн ХХҮГ-аас түлш худалдан авах мөнгөн тусламжийг 2022 оноос зохих журмын дагуу хянаж дээрх зөрчлийг арилгах, цаашид гаргахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллаж байгаа талаар аудитын явцад танилцуулаа.

Нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настанд олгох нэг талын унааны зардал:

Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 10.1.3-т заасны дагуу 2020-2022 оны эхний хагас жилийн байдлаар 1,312 ахмад настанд 345.4 сая төгрөгийн замын зардлын хөнгөлөлт олгосон байна.

Тус аймаг нь төвөөс хамгийн алслагдсан аймаг тул ихэнх ахмад настууд агаарын тээврээр зорчиж байгаагаас нэг талын унааны зардал өндөр гардаг байна. 2020-2021 онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ахмад настууд Улаанбаатар хот руу эмчилгээнд цөөн явсан байна.

Ахмад настанд хүндэтгэл

Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д заасан боловч Ковид-19 цар тахалтай холбоотой иргэдийг олноор бөөгнүүлэхгүйн тулд 2020, 2021 онд арилжааны банкаар дамжуулан хуулийн шаардлага хангасан ахмад настуудад Засгийн газрын 2018 оны 96 дугаар тогтоолд заасны дагуу жилд 2 удаа буюу нийт 20.0 мянган төгрөгөөр 2020 онд 3,806 ахмад настанд 76.0 сая, 2021 онд 6,687 ахмад настанд 89.9 сая төгрөгийг тус тус дансанд нь шилжүүлэн олгожээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх нийгмийн халамж

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасан Нийгмийн халамжийн сангаас 2020 онд 14, 2021 онд 13, 2022 онд 6 төрлийн үйлчилгээ, тусламж, хөнгөлөлт тус тус үзүүлсэн байна.

Түлш худалдан авахад нь жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн талаар

Хүснэгт №13		/сая.төг/				
Үйлчилгээний нэр	2020 он		2021 он		Нийт	
	Олгосон хүний тоо	Олголт хийгдсэн олгосон дүн	Олгосон хүний тоо	Олголт хийгдсэн олгосон дүн	Олгосон хүний тоо	Олголт хийгдсэн олгосон дүн
ХБИргэн болон хүүхэд	1518	211.4	928	129.9	2446	341.3

Эх сурвалж: /Аймгийн ХХҮГ-аас/

Хөгжлийн бэрхшээлтэй хүн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.1-д заалтын дагуу амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцүүлэн 2020, 2021 онд нийт 2,446 хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон хүүхдэд 341.5 сая төгрөгийн түлш худалдан авах мөнгөн тусламжийг хуулийн дагуу олгосон байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбоотой хөнгөлөлт:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд заасны дагуу /Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез хийлгэх, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн хөнгөлөлт/, 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас протез, сэргээн засалттай холбогдсон хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийн хөнгөлөлтөд 2020-2022 оны эхний хагас жилийн байдлаар 1,324 хөгжлийн бэрхшээлтэй хүнд 256.4 сая төгрөг олгосон байна.

“Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хууль”-ийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 80 дугаар зарлигаар 73 эхийг “Алдарт эх” I дүгээр одонгоор, 373 эхийг “Алдарт эх” II дугаар одонгоор, Ерөнхийлөгчийн 2020 оны 54 дүгээр зарлигаар 548 эхийг “Алдарт эх” I, II дугаар одонгоор, 2021 оны 111 дүгээр зарлигаар 66 эхийг “Алдарт эх” I дүгээр зэргийн одонгоор, 425 эхийг “Алдарт эх” II дугаар одонгоор шагнажээ.

Нийгмийн, халамжийн нэгдсэн цахим системд Ерөнхийлөгчийн тамгын газраас эрх үүссэн эхчүүдийн мэдээлэл холбогдсон бөгөөд шалгуур хангасан иргэнд олгодог байна.

2.2.3. Хувийн хэрэг хөтлөлт, бүрдүүлэлтэнд тавих хяналт хангалтгүй байна

Нийгмийн халамжийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авахыг хүссэн иргэдийн ирүүлсэн өргөдөл болон бусад холбогдох баримт бичгийг, өргөдлийн хамт сум, багийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн хүлээн авч хуулинд заасан хугацааны дотор холбогдох баримт бичгийг хянаж шийдвэрлэж ажилласан байна.

Аудитаар түүвэрт хамруулсан сумуудын халамжийн тэтгэврээс түүвэрт хамруулсан хувийн хэргийн хөтлөлт, бүрдүүлэлтийг шалгасан дүнг нэгтгэж үзэхэд Булган сумаас бусад сумдын хувийн хэргийн хөтлөлт, бүрдүүлэлт бүрэн, хувийн хэрэгт байгаа материалуудыг тухай бүр шинэчилж ажилласан байна.

Булган сумын халамжийн тэтгэврийн сангийн 2020 оны 1 дүгээр сараас 2022 оны 6 дугаар сарын үйл ажиллагааг хамруулан шалгахад 2020-2021 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр авсан 47, тэжээгчээ алдсаны халамжийн тэтгэвэр авсан 18 иргэний хувийн хэрэг байхгүй байна.

Мөн тухайн сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр авч байсан 60 иргэн 2020-2021 онд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актгүй байсан зөрчил илэрсэн.

Өлгий сумын халамжийн тэтгэврийн хувийн хэргийн бүрдүүлэлтийг шалгахад Буянт сумаас Өлгий суманд шилжин ирж хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр авч байсан 1 иргэн 2021 онд 4-өөс 5 сар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актгүй байна.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дотоод хяналтаар дээрх зөрчлүүдийг илрүүлээгүй бөгөөд хувийн хэрэг хөтлөлт, бүрдүүлэлтэнд тавих хяналтыг сайжруулах талаар албан шаардлага өгөгдлөө.

Байнгын асаргаатай 16 хүртэлх насны хүүхэд, 16-аас дээш насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настанд олгох асаргааны тэтгэмжийн хувийн хэргүүдийн бүрдлийг Нийгмийн халамжийн тухай хуулийн 14.1 дэх заалт, Засгийн газрын 185 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох журам”-ын 6-д заасны дагуу шалгахад нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь өргөдлийг холбогдох материалын хамт хүлээн авч, АЗД-өөр хэлэлцүүлэн, хууль журамд заасан хугацаанд шийдвэрлэн ажилласан байна.

Аудитаар түүвэрт хамруулсан сумуудын асаргааны 257 тэтгэмжийн хувийн хэргийн бүрдүүлэлтийг түүвэрлэн шалгаж үзэхэд 109 хувийн хэрэгт 2020-2022 онуудад амьжиргааг дэмжих зөвлөлийн тогтоол хавсаргаагүй, байнгын асаргаа шаардлагатай

талаар Эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтыг Амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлээгүй зөрчил дутагдал илэрсэн.

0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн хувийн хэргийн бүрдүүлэлт, олголтыг Засгийн газрын 2017 оны 12 сарын 13-ны өдрийн 340 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар баталсан “Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох журам”-ын 2.2-ын дагуу шалгасан.

Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 340 дүгээр тогтоолоор 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг сард 50.0 мянган төгрөгөөр тогтоож, 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн байна.

Дээрхи тогтоолд заасны дагуу 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж авах хүмүүс нь 7 төрлийн баримтыг бүрдүүлэн Нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд өгч, тэтгэмжид хамрагдсан байна.

2020, 2021 оны ковидын цар тахлын нөхцөл байдалтай холбоотой 2020 оны 5 сараас халамжийн үйлчилгээг цахимаар бүртгэж, цалинтай ээжүүдэд хувийн хэрэг хөтлөөгүй байна.

Энэ нь нийгмийн халамжийн сангийн e-halamj систем нь өрхийн эмнэлэг, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газартай цахимаар холбогдож, холбогдох мэдээлэл нь хүний регистрээр гарч ирэх тул хувийн хэргийг цаасаар бүрдүүлэх шаардлагагүй, илүү бодит мэдээллээр хангах боломжтой болж хяналттай болсон байна.

Аудитаар Булган сумаас бусад сумдын түүврээр цаасаар болон цахимаар бүртгэсэн 181 цалинтай ээжийн тэтгэмжийн олголтыг шалгаж үзэхэд хувийн хэргийн бүрдэл дутуу, тэтгэмжийг буруу зөрүү олгосон зөрчил дутагдал илрээгүй.

Булган сумын цалинтай ээж тэтгэмжийн олголтыг шалгаж үзэхэд 2020-2022 онуудад эрх үүсэж баталгаажиж, тэтгэмжид хамрагдсан 67 эх бүртгэлтэй ба регистрийн дугаараар нь e-halamj программд орж шалгаж үзэхэд 40 хувийн хэргийг цаасаар бүрдүүлж, тэтгэмжид хамрагдсан байна. Эдгээр 40 хувийн хэргийг аудитын явцад “олдоогүй” гэсэн шалтгаанаар шалгуулаагүй болно.

Харин дээрх 40 эхэд олгосон 43.5 сая төгрөгийн тэтгэмжийг хууль журмын дагуу үнэн зөв олгосон эсэхийг шинээр төрсөн хүүхдийн мэдээлэл, төрсөн он сар өдрөөр e-halamj программтай тулгаж үзэхэд тэтгэмжийг буруу зөрүү олгосон, төрөөгүй хүүхдэд тэтгэмж олгох эрх үүссэн зэрэг зөрчил дутагдал илрээгүй.

Эмнэлэгийн хяналтад байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний тэтгэмж, ахмад настныг асарч буй иргэний тэтгэмж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч байгаа иргэний тэтгэмж, бүтэн өнчин хүүхдийг асарч байгаа иргэний тэтгэмж, насны хишиг, өрх толгойлсон эцэх, эхийн тэтгэмж, алдар цолтон, жирэмсэн эхийн тэтгэмж авдаг нийт 4,999 иргэний хувийн хэрийн хөтлөлтийг шалгахад хувийн хэрэг хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй.

Жирэмсэн эхийн тэтгэмж авдаг нийт 1,077 иргэн цахимд шилжсэн байна.

Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөнгөлөлт тусламж, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэн, онцгой тохиолдлын болон амжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж зэрэг үйлчилгээнүүдэд хамрагдсан иргэдэд хувийн хэрэг нээдэггүй байна.

Хөнгөлөлт, тусламжид хамрагдах иргэдийн бичиг баримтыг Засгийн газрын тогтоолоор баталсан журамд заасны дагуу иргэдээс хүлээн авч аймгийн ХХҮГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтнээр хянуулж баталгаажуулсны дараа сум, баг хариуцсан мэргэжилтэнүүд програмд бүртгэж оруулснаар Сангийн яамнаас мөнгийг олгосон байна.

Ахмад настан амралт, сувиллын газарт амрах эрхийн бичгийн хөнгөлөлтийн материалыг түүврийн аргаар сонгон шалгахад Засгийн газрын 2016 оны 94 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан бичиг баримтыг бүрэн бүрдүүлж ажилласан байна.

Хүнсний эрхийн бичиг олгох журмын 2.4-д заасан материалыг бүрэн бүрдүүлж, хувийн хэргийг бүрдүүлсэн эсэхийг тулган шалгасан.

Аудитаар Өлгий сумын ХЭБ-ийн үйлчилгээнд хамрагдсан 980 өрхийн хувийн хэргээс 319 хувийн хэргийг түүвэрт хамруулан шалгахад 131 хувийн хэргийн бүрдэл дутуу, Өлгий сумын 2 болон 7 дугаар багийн хувийн хэргийн бүрдэлт сайн байна.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ олгосон Алтай сумын 78 хувийн хэргээс 26, Булган сумын 38 хувийн хэргээс 38, Дэлүүн сумын 81 хувийн хэргээс 24, Сагсай сумын 54 хувийн хэргээс 16, Ногооннуур сумын 94 хувийн хэргээс 24, Улаанхус сумын 61 хувийн хэргээс 18, Цэнгэл сумын 100 хувийн хэргээс 30 хувийн хэргийг түүвэрт хамруулан шалгахад Алтай сумын ХЭБ-ийн 11 хувийн хэргийн бүрдэлт дутуу байна.

Аймгийн ХХҮГ-ын хүнс тэжээл хариуцсан мэргэжилтэн 2022 оны 5 дугаар сард хөдөө сумуудад ажиллаж хувийн хэргийн хөтлөлт, бүрдүүлэлтийг шалгаж, зөрчилтэй, дутуу материалтай иргэдийн хүнс тэжээлийн дэмжлэг авах эрхийг нь зогсоож ажилласан байна.

Аудитын дүнгээр Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдах өрхийн хувийн хэргийн бүрдэл дутуу баримтуудыг нөхөж бүрдүүлэлт хийж баримтын бүрдүүлэлтийг бүрэн хангуулж зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүллээ.

2.2.4. Халамжийн үйлчилгээг үзүүлэхдээ давхцлыг тооцож үзээгүй байна

Халамжийн үйлчилгээг үзүүлэхдээ давхцлыг тооцож байсан эсэх талаар холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцлага хийж мэдээлэл авахад давхцлыг тооцож байгаагүй байна. Иргэд 2-6 хүртэлх халамжийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн болон хөгжлийн үйлчилгээг авч байгаа талаар мэдээлэл байгаа тул аудитын явцад давхцлыг тооцуулж судалгаа гаргууллаа.

Хууль журамд заасны дагуу эрх нь үүссэн тохиолдолд иргэдэд халамжийн тэтгэврийг давхцуулан олгосон байна. Тухайлбал: 16 нас хүртэлх асаргаа шаардлагатай хүүхэд нь асаргааны тэтгэмж, хүүхдийн мөнгө авч байгаа бол хүүхдийг асарч байгаа ээж нь асаргааны мөнгийг хууль журмын дагуу авсан байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 16-гаас дээш насны иргэн, ахмад настан нь халамжийн тэтгэвэр авч байгаа бол тухайн хүнийг асарч байгаа хүн нь асаргааны мөнгө авч байгаа гэх мэт давхардлууд байна.

Хүснэгт №14 Аймгийн халамжийн үйлчилгээний давхцлыг тооцож ирүүлсэн судалгаа

№	Халамжийн үйлчилгээний төрөл бүлгээр	2020 он	2021 он	2022 оны хагас жилийн байдлаар
---	--------------------------------------	---------	---------	--------------------------------

		Хүний тоо		
1	Халамжийн 1 төрлийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	28113	31421	20795
2	Халамжийн 2 төрлийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	21452	19307	12484
3	Халамжийн 3 төрлийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	11264	8645	7549
4	Халамжийн 4 төрлийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	408	204	123
5	Халамжийн 5 төрлийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	65	34	8
6	Халамжийн 6 төрлийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээ	22	0	0
Нийт дүн		61324	59611	40959

Эх сурвалж: ХХҮГ-аас гаргуулсан судалгаа

Дээрх судалгаанаас үзэхэд 2020 онд 6 төрлийн халамжийн үйлчилгээ авч байсан 22 хүн, халамжийн 5 төрлийн үйлчилгээ авч байсан 2020 онд 65, 2021 онд 34, 4 төрлийн үйлчилгээ авч байгаа 2020 онд 408, 2021 онд 204, 3 төрлийн үйлчилгээ авч байсан 2020 онд 11,264, 2021 онд 8,645 иргэн, 2 төрлийн үйлчилгээ авч буй хүний тоо 2020 онд 2,1452, 2021 онд 19,307 хүн байгаа бөгөөд энэхүү тоо жил тутам буурч ирсэн байна.

Дунджаар тооцож үзэхэд давхардаагүй тоогоор 2020 онд 42,712 хүн, 2021 онд 44,015 хүн халамжийн ямар нэг төрлийн үйлчилгээ авсан нь аймгийн нийт хүн амын 39-40 хувийг эзэлж байна.

Аудитын дүнгээр Аймгийн ХХҮГ-т халамжийн үйлчилгээг үзүүлэхдээ давхцлыг тооцож, хичнээн хүн халамжийн үйлчилгээнд хамрагдаж, хэдэн төрлийн үйлчилгээ авч байгаа талаар мэдээлэл, судалгаатай болох талаар зөвлөмж өгөв.

2.3 Халамжийн сангийн хөрөнгийг батлагдсан төсвийн дагуу зарцуулсан боловч 419.5 сая төгрөгийг хууль зөрчиж олгосон байна

2.3.1 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлсэн байна

Аймгийн ХХҮГ нь 2019 оноос хойш ТББ-ууд, ААН-үүдээр халамжийн үйлчилгээ үзүүлэх талаар сонгон шалгаруулалт явуулаагүй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5-д “Аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь энэ хуулийн 17.1-д заасан “олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”-г иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” гэж заасны дагуу Ахмадын хороо” ТББ, аймгийн “Улаан загалмайн хороо” ТББ, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхчүүдийн холбоо” ТББ, “Шегиртай арасан” ХХК-тай ажил гүйцэтгүүлэх гэрээ хийж, өдрийн, сургалт, сэргээн засах үйлчилгээнүүдийг үзүүлсэн байна.

2.3.2 Халамжийн тэтгэврийн сангаас 2020-2021 онд 419.5 сая төгрөгийг хууль, журам зөрчиж олгосон байна

Аймгийн Халамжийн санд улсын төсвөөс 2020 онд 20,173.6 сая, 2021 онд 8,484.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аймгийн нийгмийн халамжийн сангийн 2020-2022 оны орлого ба зарцуулалтын задаргааг хавсралт 1-ээс үзнэ үү

Хүснэгт №15

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Орлого			Зарцуулалт				Эцсийн үлдэгдэл
		Санхүүжилтийн орлого	Бусад орлого	Хүүгийн орлого	Төсвөөс	Олгогдоогүй мөнгөний заримлал	Банкны шимтгэл	Төсөвт төвлөрүүлсэн	
2020 он	204.7	20173.6	2.9	9.9	20225.3	51.7		111.5	2.4
2021 он	2.4	8484.3	1.8	0.0	8460.0	0.0	0.1	28.5	0.0
2022 он	0	227.3	0	0	223.47	0	3.82	0	0.01
Нийт орлого		28885.2	4.7	9.9	28908.7	51.7	3.9	140.0	

Эх сурвалж: Аудитын судалгаа / ХХҮГаас авсан мэдээгээр/

2020 оны эхэнд аймгийн халамжийн сангийн дансууд 204.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аймгийн Нийгмийн халамжийн сангийн төсөв 2017-2018 онуудад дутуу батлагдсаны улмаас 2018 оны жилийн эцэст 1,700.0 сая төгрөгийн өр үүссэн байсныг Засгийн газрын “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн өр барагдуулах тухай” 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 471 дүгээр тогтоолоор шийдвэрлэж, ХХҮЕГ-аас 2019 оны эцэст санхүүжилт олгосон байна.

Санхүүжилт 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхэлж орсон тул иргэдийн олгогдоогүй мөнгөнийг олгосон ба иргэд ондоо багтааж мөнгөө авч амжаагүйтэй холбоотой халамжийн сангийн дансууд оны эцэст үлдэгдэлтэй гарчээ.

Аймгийн халамжийн сан:

- 2020 онд төсвөөс 20,173.6 сая, бусад орлогоос 2.9 сая, хүүгийн орлогоос 9.9 сая, нийт 20,186.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнд 20,277.0 сая төгрөгийг зарцуулж, төсөвт 111.5 сая төгрөгийг төвлөрүүлж, оны эцэст 2.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан.
- 2021 онд төсвөөс 8,484.3 сая, бусад орлогоос 1.8 сая, нийт 8,486.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнд 8,460.1 сая төгрөгийг зарцуулж, төсөвт 28.5 сая төгрөгийг төвлөрүүлж оны эцэст үлдэгдэлгүй байна.
- 2022 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвөөс 223.5 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Халамжийн сангийн 2020-2022 оны батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэлийг хавсралт 2-оос харна уу /Орон нутгийн төсөв ороогүй дүнгээр/

Хүснэгт №16

Үзүүлэлт	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл		Зөрүү	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
2020 он	55040	20174.7	54182	20277.0	-858	102.3
2021 он	38040	8484.3	55838	23074.5	-4488	8254.2
2022 он	25792	2902.8	40939	11756.05	-13801	-1838.6

Эх сурвалж: Аудитын судалгаа / ХХҮГаас авсан мэдээгээр/

ХХҮЕГ-аас аймгийн Халамжийн сангийн 2020 оны төсвийг 20,174.7 сая төгрөгөөр баталж, төсвийн хуваарь ирүүлсэн ба гүйцэтгэлээр 20,277.0 сая төгрөгийг

зарцуулсан байна. Өмнөх оны олгогдоогүй үлдэгдлийг олгосонтой холбоотой гүйцэтгэл илүү байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлсэнтэй холбоотой 2021 онд аймгийн нийгмийн халамжийн сангийн төсөв өмнөх оноос 11,690.4 сая төгрөгөөр буурч батлагдсан байна. Батлагдсан төлөвлөгөөнөөс 2021 оны гүйцэтгэл 14,590.2 сая, 2022 оны гүйцэтгэл эхний хагас жилийн байдлаар 8853.2 сая төгрөгөөр илүү байгаа нь аймгийн ХХҮГ-ын данс руу санхүүжилт шилжүүлэхгүйгээр Сангийн яамнаас иргэдийн нэрийн данс руу шууд олголт хийсэнтэй холбоотой байна.

Эхний ээлжинд 2020-2021 онд жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, тэтгэмж, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж, өрх толгойлсон эх/эцгийн тэтгэмж, насны хишиг, эхийн алдарт одонтой эхэд олгох мөнгөн тусламж, алдар цолтон ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, тусламж, хүүхдийн мөнгөн тэтгэмжүүдийг, 2022 оны 2 дугаар сараас ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт тусламж, хүнсний эрхийн бичгийн хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээг тус тус үе шаттайгаар И-халамж нэгдсэн систем рүү шилжүүлснээр халамжийн бүх төрлийн үйлчилгээ цахимжсан байна.

Үүнтэй холбоотойгоор ХХҮЕГ нь нэгдсэн төсөвтэй болж аймаг, дүүргийн ХХҮГ-ын данс руу санхүүжилт шилжүүлэхгүйгээр Сангийн яамнаас иргэдийн нэрийн данс руу шууд шилжүүлдэг болсон тул тухайн үйлчилгээнүүд И-халамж уруу шилжих хүртэл аймаг, дүүргүүдэд санхүүжилт олгож, шилжнээс хойш санхүүжилтийг зогсоосон байна. Иймд батлагдсан төсөв болон санхүүжилтийн дүн нь гүйцэтгэлийн дүнгээс бага байна.

Аймгийн Халамжийн сангийн 2020-2021 он болон 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг харьцуулсан судалгааг хавсралт 3-аас харна уу.

Хүснэгт №17

Үзүүлэлт	2020 оныг гүйцэтгэл		2021 оныг гүйцэтгэл		2022 оныг гүйцэтгэл		Зөрүү /2021-2022/		Зөрүү /2022-2021/
2020 он	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо
Нийт дүн	54182	20,277.0	55838	23,074.5	40939	11,756.1	1656	2797.5	13133

Эх сурвалж: Аудитын судалгаа

Аймгийн Халамжийн сангийн гүйцэтгэлээс харахад 2021 оны байдлаар ахмад настанд үзүүлэх, хөнгөлөлт, тусламж авсан хүний тоо 3088-аар, алдарт эхийн одонгийн мөнгө авсан хүний тоо 825-аар, цалинтай ээж хөтөлбөрт хамрагдсан хүний тоо 144-өөр нэмэгдсэн бол бусад тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнд хамрагдсан хүний тоо 83-аас 1709 хүнээр буурсан байна. Үүнээс: Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт урамшуулал авсан хүний тоо 1,709 хүнээр, халамжийн тэтгэвэр авсан хүний тоо 320 хүнээр буурсан байна.

Аймгийн халамжийн сангийн 2022 оны гүйцэтгэлийг 2021 онтой харьцуулж үзэхэд: халамжийн үйлчилгээ авсан иргэдийн тоо 4-9969 хүнээр буурсан байна. Үүнээс ахмад настанд үзүүлэх, хөнгөлөлт, тусламж авсан хүний тоо 9969 хүнээр, халамжийн тэтгэвэр авсан хүний тоо 206 хүнээр хүнс тэжээлийн дэмжлэг авч байгаа хүний тоо 3842 хүнээр тус тус буурсан байна.

Дээрх байдлаас үзэхэд зарим халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжууд болон хүнсний эрхийн бичиг авч байгаа иргэдийн тоо буурч байгаа нь харагдаж байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар “Тэтгэвэр, тэтгэмжийн сангийн хөрөнгийг зөвхөн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид зарцуулна”, 8.2-т “Нийгмийн үйлчилгээний сангийн хөрөнгийг хуулийн 8.2.1-8.2.9-д заасан үйлчилгээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулахаар хуульчилсан.

Аудитаар нийгмийн халамжийн тэтгэвэр олголтыг хууль журамд заасны дагуу арвилан хэмнэлттэй зарцуулаагүй, халамжийн тэтгэвэр олголтыг хууль журам зөрчиж олгосон нийт 419.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

- Түүвэрт хамруулсан сумууд нийт 35 иргэнд халамжийн тэтгэврийг тогтоосон хэмжээнээс 9600-74323 төгрөгөөр буюу нийтдээ 0.5 сая төгрөгийг илүү олгосон.
- Алтай, Өлгий сумын халамжийн тэтгэврийн сангаас 2 иргэнд 2021 оны 11 дүгээр сард тус бүр нэг сарын нийт 0.6 сая төгрөгийн халамжийн тэтгэврийг илүү олгосон.
- Буянт сумын халамжийн тэтгэврийн сангаас Өлгий сумын 11 дүгээр багт шилжиж ирсэн 1 иргэнд 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 9 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актгүйгээр 1.4 сая төгрөгийн халамжийн тэтгэврийг олгосон.
- Булган сумын халамжийн сангаас 2020-2021 онд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актгүйгээр 125 иргэнд нийтдээ 417.4 сая төгрөгийн халамжийн тэтгэврийг хууль бусаар олгосон байна.

Аудитаар түүвэрт хамруулсан сумуудын халамжийн тэтгэврийн материалыг аймагт татан авч шалгах явцад эрсдэлтэй байгаа нь ажиглагдсан тул Булган суманд газар дээр нь ажиллаж 2020 оноос 2022 оны 6 дугаар сарыг дуустал хугацааны халамжийн тэтгэврийн олголтыг Ehalamj цахим програмаас татан авч 100 хувь шалгалтанд хамруулсан.

Аудитын дүнгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр авсан 53 иргэн болон тэжээгчээ алдсаны халамжийн тэтгэвэр авсан 18 иргэний хувийн хэрэг байхгүй, хувийн хэрэгтэй боловч хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актгүйгээр 65 иргэнд халамжийн тэтгэвэр олгосон нь тогтоогдсон.

Нийгмийн халамжийн сангаас үзүүлж буй үйлчилгээнүүдийг Ehalamj цахим программд шилжихээс өмнө WAIS программаар олгож байсан бөгөөд сум, баг хариуцсан мэргэжилтэн нар анхан шатны бичиг баримт болон сунгалт хийлгэж ирсэн үйлчилгээнүүдийг программд өөрсдөө шивж оруулан өөрсдөө баталгаажуулалт хийж байжээ.

Нийгмийн халамжийн сангаас үзүүлж буй үйлчилгээнүүдийг 2021 оны 2 дугаар сараас эхлэн e.halamj.mn цахим системд шилжүүлж, 6 дугаар сараас эхлэн анхан шатны бичиг баримтуудыг сум, баг хариуцсан мэргэжилтэн нар хүлээн авч e.halamj.mn цахим системд бүртгэдэг болсон ба баталгаажуулалтыг хяналтын хоёр ахлах мэргэжилтэн болон олголт хариуцсан мэргэжилтэн хийдэг зохицуулалттай болсон байна.

Булган сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь 2021 оны 3 дугаар сард КОВИД-19 цар тахалт өвчнөөр өвчилж, улмаар 6-р сард уг өвчний улмаас нас барсан байна.

Булган сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь 2020 оны 1 дүгээр сараас эхлэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актгүй иргэдэд тэтгэвэр тогтоож, мэдээллийн санд оруулаад мөнгө олгож байгаад нас барахын өмнө буюу 2021 оны 4, 5 дугаар саруудад өөрөө зогсоосон байна.

Аудитийн явцад дээрх иргэдийн жагсаалтыг аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст албан тоотоор хандаж шалгуулсан ба Нийгмийн даатгалын хэлтсээс хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон акттай эсэхийг тодруулж албан бичгээр хариу ирүүлсэн.

Дээрх асуудал нь гэмт хэргийн шинжтэй үйлдэл боловч энэ асуудлыг хариуцдаг Булган сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон аймгийн ХХҮГ-ын даргаар ажиллаж байсан хүн нас барсан тул хариуцах эзэнгүй болсон байна.

Иймд аймгийн ХХҮГ-ын одоогийн дарга, Захиргаа хяналтын хэлтсийн бүрэлдэхүүн, Нийгмийн халамжийн хэлтсийн дарга, сангийн болон олголтын мэргэжилтэн, Булган сумын хөдөлмөр, халамжийн асуудал эрхэлсэн мэргэжилтэн нарт хариуцуулан 417.0 сая төгрөгийг 2023 оны 11 дүгээр сарын 01-ний дотор төсөвт нөхөн төлүүлэх арга хэмжээ авч, улсыг хохиролгүй болгохоор төлбөрийн акт тогтоолоо.

Мөн халамжийн тэтгэврийг тогтоосон хэмжээнээс илүү олголт хийсэн 0.5 сая, Алтай, Өлгий сумын халамжийн тэтгэврийн сангаас 2 иргэнд илүү олгосон 0.6 сая, Буянт сумын халамжийн тэтгэврийн сангаас Өлгий сумын 11 дүгээр багт шилжиж ирсэн иргэнд 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 9 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хугацаанд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон актгүйгээр олгосон 1.4 сая төгрөг буюу нийт 2.5 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Аудитын дүнгээр аймгийн Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоодын хяналтыг сулруулж, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн, хариуцлага алдсан аймгийн ХХҮГ-ын Захиргаа, хяналтын хэлтсийн дарга, ахлах мэргэжилтнүүд, Нийгмийн халамжийн хэлтсийн дарга, халамжийн сангийн ахлах мэргэжилтэн болон олголтын мэргэжилтэн нарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлээ.

2.3.3 Орон нутгийн төсвөөс халамжийн үйлчилгээнд баталсан хөрөнгийг батлагдсан төсвийн дагуу зарцуулжээ

Орон нутгийн төсвөөс халамжийн үйлчилгээнд 2020-2022 оны хагас жилийн байдлаар нийтдээ 443.4 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 377.0 сая төгрөгийг зарцуулж 65.6 сая төгрөг хэмнэгдэж, санхүүжилтийн үлдэгдэлийг аймгийн төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн байна. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмжийн зардал 2.4-65.6 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмж жил бүр хэмнэгдэж байгаа нь тухайн онд бүтэн өнчин болох, гамшиг тохиолдох, хэдэн хүн хорих ангиас суллагдах нь тодорхойгүй, гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой.

Хүснэгт №18		/сая.төг/					
Он	Халамжийн үйлчилгээний төрөл	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл		Зөрүү	
		Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
2020	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмж	100	150.6	86	102.2	14	48.4

	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ /ОНОТХҮйлчилгээ	211	24.4	211	24.4	0	-
	Дүн	311	175.0	297	126.6	14	48.4
2021	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмж	80	102.0	83	99.6	-3	2.4
	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	558	66.4	558	66.4	0	-
	Дүн	638	168.4	641	166.0	-3	2.4
2022	Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмж	70	80.0	12	14.4	58	65.6
	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	277	20.0	20	20.0	257	-
	Дүн	347	100.0	32	34.4	315	65.6

Эх сурвалж: /Аймгийн ХХҮГ-аас/

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсөвт 2020-2022 онд 110.8 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр бүрэн зарцуулжээ. Орон нутгийн төсвөөс халамжийн үйлчилгээнд зориулан батлагдсан нийт төсвийн 24.9 хувийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төсөв эзэлж байгаа нь шаардлагатай төсөв, хөрөнгө дутагдалтай байгааг харуулж байна.

Орон нутгийн төсвөөс нийгмийн халамжийн сангийн Онцгой тохиолдлын тэтгэмж, амьжиргааг дэмжих тэтгэмж болон Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан ажилласан байна.

2.4. Хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн байна

2.4.1 Хүнсний эрхийн бичгийг эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөлд олгожээ

Үндэсний статистикийн хороо болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан аргачлал /орлогыг орлуулан тооцох аргачлал/-ын дагуу амьжиргааг түвшингээ үнэлүүлж, өрхийн гишүүн-иргэний мэдээллийн нэгдсэн санд орсон нийгмийн халамжийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнээс тухайн онд хүнсний эрхийн бичиг олгохоор Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан босго онооноос доогуур байгаа өрхийн гишүүн иргэнийг энэ үйлчилгээнд хамруулсан байна.

Хүнсний эрхийн бичиг олгох журмын 2.5-д “Өргөдөлд өрхийн гишүүн-иргэдийг төлөөлөн хүнсний эрхийн бичиг авах насанд хүрсэн нэг гишүүнийг тодорхойлсон байна” гэж заасны дагуу тухайн хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээнд хамрагдсан өрхөөс өрхийн тэргүүнийг тодорхойлдог байна. Тухайн өрхийн тэргүүн нас барсан, шилжсэн тохиолдолд өрхийн дараагийн гишүүнд шилжүүлэх журмаар зохицуулж иржээ. Үүнтэй холбоотой эрх бүхий итгэмжлэгдсэн төлөөлөл буюу өрхийн тэргүүнээс бусад иргэн цахим картыг хэрэглэсэнтэй холбоотой өргөдөл, гомдол гараагүй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар баталсан Хүнсний эрхийн бичиг олгох журамд ажил хайж, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад бүртгүүлсэн, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд хамрагдсан, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаас санал болгосон арга хэмжээнд 2-оос доошгүй үйл ажиллагаанд хамрагдсан нийгмийн халамжийн дэмжлэг зайлшгүй шаардлагатай өрхүүдийг хамруулахаар журамласан.

Аудитаар түүвэрт хамруулж шалгасан Өлгий, Алтай, Дэлүүн, Улаанхус, Цэнгэл, Ногооннуур сумууд дээрх хууль, журамд заасан шалгуур хангасан иргэдийг хүнсний эрхийн бичигт хамруулсан байна.

2.4.2 Хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээнд хамрагдсан өрхөөс зохих түвшинд хасалт хийгджээ

Хүнсний эрхийн бичигт хамрагдаж байгаа өрхүүдээс журамд зааснаар гурав ба түүнээс дээш гишүүн ам бүлийн тооноос хасагдсан, аймаг, нийслэл хооронд шилжсэн, 2 сарын хугацаанд ашиглаагүй бол түдгэлзүүлэх журамтай.

Түүнчлэн хүнсний эрхийн бичигт хамрагдах хугацааг 2 жил болгож, хөдөлмөрийн насны иргэнийг 2 буюу түүнээс дээш удаагийн тохирсон ажлын байранд зуучлахад татгалзсан тохиолдолд дэмжлэгээс хасах нөхцөлийг тавьж хэрэгжүүлснээс гадна 200-аас дээш малтай өрх, 2-оос дээш орон сууцны байшин, 2-оос дээш бие даасан тохилог сууц, 2-оос дээш авто машинтай өрхийг тус үйлчилгээнээс гаргахаар зохицуулжээ.

Аймгийн хэмжээнд 972 өрх хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээнээс хасагдсан бөгөөд 2020 онд 61 өрхийн 347, 2021 онд 493 өрхийн 3003, 2022 онд 418 өрхийн 2354 иргэн тус тус хасагдсан байна.

Хүснэгт №19

№	Сумдын нэр	2020 он		2021 он		2022 оны 9 сарын байдлаар	
		Өрхийн тоо	Хүний тоо	Өрхийн тоо	Хүний тоо	Өрхийн тоо	Хүний тоо
1	Алтай сум	0	0	17	112	14	75
2	Алтанцөгц сум	3	22	17	105	0	0
3	Баяннуур сум	2	11	49	322	0	0
4	Бугат сум	18	105	9	51	3	12
5	Булган сум	2	12	19	138	35	209
6	Буянт сум	0	0	13	76	8	45
7	Дэлүүн сум	1	3	27	162	9	56
8	Ногооннуур сум	0	0	24	149	5	30
9	Сагсай сум	1	7	31	192	14	76
10	Толбо сум	5	29	19	119	3	15
11	Улаанхус сум	5	29	27	181	101	579
12	Цэнгэл сум	0	0	33	207	16	84
13	Өлгий сум	24	129	208	1189	210	1173
		61	347	493	3003	418	2354

Эх сурвалж: ХХҮГ-ын мэдээ, тайлан

Өлгий сумаас 2020 онд 129, 2021 онд 1189, 2021 онд 1173 иргэн хасагдсан нь дийлэнх хувийг эзэлж байна.

Аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг гарч аймгийн хэмжээний бүх сумуудад хяналт шалгалт хийж хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхүүдийг 2021 оны жилийн эцсийн А данстай тулгалт хийж, малтай, машинтай, шинээр байшин барьсан өрхүүдийг журмын 5.2.4-т заасны дагуу түдгэлзүүлсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №20

		Үүнээс
--	--	--------

Сумын нэр	Журмын дагуу түтгэлзсэн нийт өрхийн тоо	Аймаг нийслэл хооронд шилжсэн	3-аас дээш гишүүн шилжсэн өрх	100-аас дээш малтай өрх	Тусдаа гарсан өрх	Шинээр байшин барьсан	Тэтгэвэр, тэтгэмж авдаг өрх	Байнгын ажлын байртай	Авто-машинтай өрх
Алтай	15	1		14					
Булган	23			18	5				
Толбо	8			6		2			
Сагсай	12			8			3	1	
Дэлүүн	11	2					6		3
Цэнгэл	17	1	2	12				2	
Улаахус	33		5	16		12			
Бүгд	119	4	7	74	5	14	9	3	3

Эх сурвалж: ХХҮГ-ын мэдээ, тайлан

Шалгалтаар нийт 119 өрхийг хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс түдгэлзүүлж, 100-аас дээш малтай 74 өрх, шинээр байшинтай болсон 14 өрхийг тус үйлчилгээнээс хассан байна. Ажлын хэсгийн гишүүд Өлгий сумын 13 багийн хүнсний үйлчилгээнд хамрагдаж байгаа айлуудад шалгалт хийж амьжиргааны түвшин сайжирсан 125 өрхийг журмын дагуу зогсоосон байна.

Үүнээс гадна Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 2021 оны 7 дугаар сард хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс хасах 52 өрхийн жагсаалт ирсний дагуу журмын 5.2.4 дэх заалтыг үндэслэн үйлчилгээнээс бүрэн түдгэлзүүлсэн байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас 2021 оны 10 дугаар сард төрийн байгууллагын мэдээлэлтэй тулгалт хийж хүнс тэжээлийн дэмжлэг авдаг айлуудаас хөдөлмөр эрхэлж, нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа 322 иргэний жагсаалт, 100-аас дээш толгой малтай, суудлын автомашинтай, 2 байшинтай болсон 287 өрхийн жагсаалтыг ирүүлсэн байна.

Үүний дагуу аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын сум, баг хариуцсан мэргэжилтнүүд тухайн иргэдэд жагсаалтыг танилцуулж, амьжиргаа дэмжих зөвлөл тухайн айл өрхүүдэд очиж ажиллан, холбогдох байгууллагуудтай тулгалт хийж хөрөнгө нь батлагдсан айл өрхүүдийн хүнс тэжээлийн дэмжлэгийг зогсоосон байна.

2.4.3 Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүрийн сонгон шалгаруулалтыг 2019 онд зохион байгуулж, 2020 онд гэрээг сунгасан байна

Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/52 дугаар захирамжаар Өлгий сумын зорилтод өрхийн гишүүдэд хүнсний эрхийн бичгээр бараа нийлүүлэх дэлгүүрүүдийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулсан байна.

Өлгий сумын хэмжээнд нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 1,410 өрхийн 7,701 иргэнд хүнсний эрхийн бичгээр хүнс нийлүүлэх БӨАОНӨГ/201902061/01/01 дугаар бүхий нээлттэй тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.2.2 дахь заалтын дагуу зохион байгуулсан байна.

Тендерийн сонгон шалгаруулалтыг 80 өрх тутамд нэг дэлгүүр, 80-аас дээш өрх тутамд хоёр дэлгүүр байхаар зохион байгуулжээ. Сонгон шалгаруулалтад 35 компани санал ирүүлснээс Үнэлгээний хорооны дүгнэлтээр 13 багцад 19 дэлгүүрийг сонгон

шалгаруулж, гэрээ байгуулж ажиллахыг аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлсэн байна.

Сонгон шалгаруулалтын 4 багцад маргаан гарч 2019 оны 06 дугаар сарын 10-д БӨАОНӨГ/201906001 дугаар тендерийг дахин зарлаж, 2019 оны 07 дугаар сарын 26-нд сонгон шалгаруулалт явуулсан байна. Тендер шалгаруулалтад Өлгий сумын 4, 6, 10, 11 дүгээр багуудын нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 448 өрхөд хүнсний эрхийн бичгээр хүнс нийлүүлэх 8 дэлгүүрийг сонгон шалгаруулсан байна.

Монгол Улсын Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 дугаар тушаалаар баталсан Хүнсний эрхийн бичиг олгох журмын 6.7-д “Тухайн сум, дүүрэгт хүнсний эрхийн бичгээр үйлчлэх өрхийн тоо 30 ба түүнээс дээш байх тохиолдолд үйлчлэх дэлгүүрийн тоо 2 ба түүнээс дээш байхаар тогтооно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүрийг сонгон шалгаруулах ажлыг сумдад сумын Засаг дарга нар хүнсний эрхийн бичгээр бараа нийлүүлэх дэлгүүрүүдийг сумын хэмжээнд сонгон шалгаруулсан бөгөөд 13 сум 23 дэлгүүртэй хүнсний эрхийн бичигт хамрагддаг зорилтот бүлгийн иргэдэд үйлчлэх гэрээ байгуулан ажиллажээ.

Аймгийн хэмжээнд ХЭБ-ийн үйлчилгээ үзүүлэхээр шалгарсан нийт 44 хүнсний дэлгүүртэй гэрээ байгуулан журамд заасан 10 нэр төрлийн барааны шалгуур хангасан өрхүүдэд хүргэж ажилласан байна.

Харин 2020 онд сонгон шалгаруулалт явуулаагүй бөгөөд амьжиргаа дэмжих зөвлөл хүнсний эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлдэг дэлгүүрүүдийн гэрээг дүгнэж үргэлжлүүлэн ажиллуулах талаар хэлэлцэж гэрээний биелэлт “хангалттай” гэж дүгнэсэн дэлгүүрүүдийн гэрээг сунгасан байна.

2021 оны хүнсний дэлгүүрийн сонгон шалгаруулах БӨАХХҮГ/20210100 дугаартай зарыг tender.gov.mn цахим хуудсанд байршуулан, 41 багцтай тендер зарлаж, ХХҮГ-ын даргын 2020 оны 11 дүгээр сарын 16-ний өдрийн А/23 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулжээ. Тендерт 111 аж ахуйн нэгжийн материал ирүүлснийг хүлээн авч, сонгон шалгаруулалт явуулсан боловч үнэлгээний дүнг гаргаагүй байна.

ХНХСайдын 2021 оны 03 дугаар сарын 05-ний өдрийн 1/581 дугаар чиглэл хүргүүлсэн албан бичгийг үндэслэн дээрх тендер сонгон шалгаруулалтыг цуцалсан мэдэгдлийг ААН-үүдэд 2021 оны 03 дугаар сарын 12-ний өдөр хүргүүлсэн байна.

Хүнсний эрхийн бичиг олгох арга хэмжээг нээлттэй, ил тод, тэгш хүртээмжтэй, сонголттой, хяналттай болгох зорилгоор Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ыг шинэчилж 2021 оны 07 дугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн байна.

Журмын шинэчлэлээр хүнсний эрхийн бичигт хамрагддаг зорилтот бүлгийн иргэд зөвхөн гэрээт дэлгүүрээр үйлчлүүлдэг байсныг болиулж, 10 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг баркоджуулснаар НӨАТ-ын баримт буюу и-баримт хэвлэдэг хүнсний дэлгүүр, томоохон супермаркет, зах, бөөний төвөөр үйлчилгээ үзүүлдэг болгож зохицуулжээ.

Энэхүү ажлын хүрээнд иргэдийг пин коджуулах, пос машины хөгжүүлэлт, хүнсний бүтээгдэхүүнийг баркоджуулах, сервисийн хөгжүүлэлт зэрэг ажлуудыг шат дараатайгаар төр, хувийн байгууллага хамтран зохион байгуулсан байна.

2.4.4 Хүнсний эрхийн бичгээр үйлчилдэг дэлгүүрүүдэд хяналт тавьж ажиллаагүй байна

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 дугаар тушаалаар баталсан Хүнсний эрхийн бичиг олгох журмын 6.5-д “Аймаг, дүүргийн нийгмийн халамжийн үйлчилгээний байгууллага нь аймгийн төвийн сум болон дүүрэгт хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулна” гэж заасны дагуу 2019 онд сонгон шалгаруулсан дэлгүүрүүдэд сумын Засаг дарга нар гэрээ байгуулан ажиллажээ.

Сумдын амьжиргаа дэмжих зөвлөл хуралдаж хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлдэг дэлгүүрүүдийн гэрээний биелэлтийг дүгнэж, гэрээний биелэлт хангалттай, иргэдээс гомдол мэдүүлээгүй дэлгүүрүүдийн гэрээний хугацааг сунгаж ажиллуулах талаар аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт албан тоот хүргүүлсэн байна.

2020 онд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, журмын 6.12-т заасныг зөрчсөн, бүтээгдэхүүний үнийг үндэслэлгүйгээр нэмсэн тохиолдол гарч гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдол гараагүй байна.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 дугаар тушаалаар баталсан “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ын 6.9-т “Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүр нь эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлын баталгааг бүрэн хангасан хүнсний бүтээгдэхүүнийг зах зээлийн дундаж үнээр худалдана” гэсэн заалт хүчингүй болсноор дэлгүүрүүд зах зээлийн үнэ ханшийг баримталж байгаа эсэхийг хянах боломжгүй байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар батлагдсан “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ын 6.11-т “Энэ журмын 6.5-д заасан аж ахуйн нэгж, худалдаа эрхлэгч, хүнсний дэлгүүр нь НӨАТ-ын баримт, картын мэдээллийг нэгтгэн хэвлэдэг төхөөрөмжтэй байх шаардлагатай” гэж заасан боловч хүнсний эрхийн бичгийн төлбөрийн картаар хаанаас авч байгааг хянах боломжгүй, дэлгүүрүүдтэй гэрээ хийх, хууль зөрчсөн дэлгүүрүүдэд хариуцлага хүлээлгэх заалт байхгүй болсон байна.

Гүйцэтгэлийн аудитаар аймгийн төвийн дэлгүүрүүдээс түүвэрлэн шалгалт хийхэд дараах зөрчлүүд илэрч, зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

- 1) Өлгий сумын хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүрийн картын мэдээллийг нэгтгэдэг программын ашиглалтыг шалгахад “Чингисхаан” дэлгүүр программ ашиглаагүй, “Сансар”, “Сумо” дэлгүүр 5 сар ашигласан, “Күнгей”, “Асыл” дэлгүүрүүдийн программын лицензийн хугацаа дууссан. Иргэдийн гомдлын дагуу шалгахад “Оргил”, “Ахмарал” дэлгүүрүүдэд журамд заасан 10 нэр төрлийн бараа бүтээгдэхүүний сонголт муу, “Оргил”, “Ахмарал”, “Мариям” дэлгүүрүүд гурил, гурилан бүтээгдэхүүнийг хүнсний зах, бусад бөөний дэлгүүрүүдээс авч тараадаг байна



“Оргил дэлгүүр”



“Ахмарал” дэлгүүр

- 2) Оргил” дэлгүүр 26, “Асыл” дэлгүүр 13, “Сансар” дэлгүүр 15, “Нурсолтан” дэлгүүр 31, “Андууд” дэлгүүр 33, “Ахмарал” дэлгүүр 40, нийт 158 ширхэг төлбөрийн картыг хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдах өрхийн гишүүдээс хураан авч хадгалж байсан. Дэлгүүрийн картын мэдээллийг нэгтгэдэг программыг шалгахад төлбөрийн картыг сар болгон тухайн нэг өдөр бөөнөөр нь уншуулдаг байна. Энэ нь уг үйлчилгээнд хамрагддаг өрхүүдийн сонголт хийх эрхийг хязгаарлаж, хүнсний эрхийн бичгээр үйлчлэх төлбөрийн картын ашиглалт, хяналт хангалтгүй байгааг харуулж байна.



“Андууд” дэлгүүрийн 33 ш карт



“Ахмарал” дэлгүүрийн 40 ш карт

- 3) Хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүрүүдийн бараа бүтээгдэхүүний зах зээлийн үнэ ханшийг судалж үзэхэд “Ариун шинэ давлагаа” ХХК-ны “Дэлүүн” хүнсний дэлгүүр бусад хүнсний дэлгүүрүүдэд 60.0-62.0 мянган төгрөгөөр худалдаж байсан 50 кг “Ургац” гурилыг 72.0 мянган төгрөгөөр, 30.0-32.0 мянган төгрөгөөр худалдаж байсан 25 кг “Ургац” гурилыг 39.0 мянган төгрөгөөр хүнс тэжээлийн дэмжлэг авдаг айлуудад худалдаж байсан нь картын мэдээллийг нэгтгэдэг программаар нотлогдсон.

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 дугаар тушаалаар баталсан Хүнсний эрхийн бичиг олгох журмын 10.6-д “Хүнсний эрхийн бичгээр үйлчилж буй банк болон дэлгүүр нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, энэ журмын 6.12-т заасныг зөрчсөн, бүтээгдэхүүний үнийг үндэслэлгүйгээр нэмсэн

тохиолдолд талууд гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж, учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ” гэж заасан заалт хүчингүй болсноор зах зээлийн ханшнаас өндөр үнээр зардаг дэлгүүрүүдэд хариуцлага хүлээлгэх боломжгүй болсон байна.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтнүүд 2021 онд бүх дэлгүүрүүдээс хүнсний эрхийн бичгийн цахим картыг хураан авч карт эзэмшдэг өрхүүдэд тарааж өгсөн боловч дэлгүүрүүд картыг өрхүүдээс авч хадгалдаг хэвээр байна. Үүнийг дэлгүүрийн эздээс тодруулахад хүнсний эрхийн бичигт хамрагдсан өрхүүд хүнсний бүтээгдэхүүнийг зээлээр авч, цахим картыг барьцаанд үлдээдэг байна.

Хүнсний эрхийн бичгээр үйлчилдэг дэлгүүрийн кассын машинаас гаргасан баримтаас үзэхэд бүх өрхөд ижил төрлийн бүтээгдэхүүн олгосон, өрхүүд сар болгон тогтмол ижил төрлийн бүтээгдэхүүн авч байсан байна.

Дэлгүүрүүд иргэдэд бараа олгосон бүртгэл, нотлох баримт байхгүй, программын лиценз дууссан, программын ашиглалт тааруу, барааны сонголт муу, гурил, гурилан бүтээгдэхүүнүүдийг бусад дэлгүүр, хүнсний захаас авч хүнс тэжээлийн дэмжлэгт хамрагдсан өрхүүдэд үнэ нэмж зардаг, тээврийн хөлсний мөнгө нэхдэг асуудал байсан бөгөөд халамжийн байгууллагаас дэлгүүрүүдтэй гэрээ байгуулдаггүй тул хяналт тавих боломжгүй байна.

Дэлгүүрүүдийн НӨАТ-ын баримт хэвлэдэг программд ХЭБ-ийн цэс хамт байдаг боловч программын хугацаа дууссан ч сунгуулдаггүй, ХЭБ-ийн цэсийг 3 хоног тутам илгээх товч дарж мэдээллийг илгээх ёстой боловч бүрэн хэрэгжүүлдэггүй байна.

2.4.5 Хүнс тэжээлийн дэмжлэг нь ядуурлыг бууруулж, зорилтод бүлгийн иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд төдийлөн нөлөө үзүүлээгүй байна

Үндэсний статистикийн хороо болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан аргачлалын дагуу амьжиргааны түвшнийг үнэлүүлж, өрхийн мэдээллийн санд орсон, амьжиргааны түвшний үнэлгээ нь 310 босго оноотой тэнцүү буюу түүнээс доош оноотой өрхүүдийг хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээнд хамруулдаг байна.

Амьжиргааны түвшин тогтоох судалгааг улсын хэмжээнд 2017 онд явуулсан бөгөөд цар тахалтай холбоотой дахиж явуулаагүй байна.

Засгийн газрын 2014 оны 404 дүгээр тогтоолоор баталсан “Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журам”-ын 2.3-т мэдээллийн санг бүрдүүлэхэд ашиглаж байгаа аргачлалыг нийгэм, эдийн засгийн өөрчлөлттэй уялдуулан 3 жил тутамд шинэчлэхээр заасан байна. Гэтэл 2017 оноос өнөөдрийг хүртэл өрхийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлээгүй, тухайн үеийн мэдээлэлд тулгуурлан хүнсний эрхийн бичгийг олгож ирсэн байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд тухайн өрхийн орлого болон хөрөнгийг нь тооцоолж байгаа боловч тухайн өрхийн сарын орлого, зээлийн талаарх мэдээллийг оруулаагүй байгаа нь зорилтот эмзэг бүлгийн иргэдийг зөв тодорхойлж чадаагүй гэж үзэж болохоор байна.

Баян-Өлгий аймгийн хэмжээнд хүнс тэжээлийн дэмжлэгт 2020 онд 3,389.6 сая төгрөг, 2021 онд 1,978.5 сая төгрөг, 2022 оны эхний хагас жилийн байдлаар 779.8 сая төгрөгийн хөрөнгийг босго оноо 310 оноо болон түүнээс доош орсон 1,679-2,550 өрхөд олгосон байна.

Хүснэгт №21

Сар	2020 оны байдлаар		2021 оны байдлаар		2022 оны байдлаар	
	өрхийн тоо	мөнгөн дүн	өрхийн тоо	мөнгөн дүн	өрхийн тоо	мөнгөн дүн
1	2,481	173,448,000	2,523	178,512,000	1,992	138,328,000
2	2,494	174,024,000	2,428	171,328,000	1,971	137,304,000
3	2,524	176,144,000	2,427	170,912,000	1,858	131,784,000
4	2,524	176,520,000	2,398	168,760,000	1,851	128,640,000
5	2,539	355,568,000	2,393	169,032,000	1,864	128,944,000
6	2,548	356,640,000	2,380	168,808,000	1,679	114,792,000
7	2,547	357,600,000	2,385	168,288,000		
8	2,546	357,872,000	2,333	164,040,000		
9	2,538	357,296,000	2,332	164,520,000		
10	2,550	303,568,000	2,299	161,536,000		
11	2,532	301,432,000	2,192	153,584,000		
12	2,508	299,472,000	2,016	139,208,000		
Дүн	30,331	3,389,584,000	28,106	1,978,528,000	11,215	779,792,000

Эх сурвалж: ХХҮГ-ын мэдээ, тайлан

Ковид-19 цар тахалтай холбоотой 2020 оны 5 дугаар сараас хүнсний эрхийн бичгийн мөнгөн дүнг хоёр дахин нэмэгдүүлэн олгосонтой холбоотой 2020 онд санхүүжилтийн хэмжээ өссөн дүнтэй харагдаж байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд сард олгох хүнсний эрхийн бичгийн үнийн дүнг 2014 оноос нэг хүүхдэд 5000 төгрөгөөр, насанд хүрсэн нэг гишүүнд 10000 төгрөгөөр олгож ирсэн бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/103 дугаар тушаалаар нэг хүүхдэд 8000 төгрөгөөр, насанд хүрсэн нэг гишүүнд 16000 төгрөгөөр нэмэгдүүлэн олгосон байна.

Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ 2021 оноос хойших өсөлтөд хүнсний эрхийн бичгийн мөнгөн дүн нь ядуурлыг бууруулж, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн өдөр тутмын хүнс тэжээлийн хэрэгцээг хангаж чадахгүй хэмжээнд хүрсэн байна. Жишээ нь: Баян-Өлгий аймагт нэг шуудай гурилын үнэ дунджаар 95.0 мянган төгрөг бөгөөд 3 хүүхэдтэй өрхийн хүнсний эрхийн бичгийн сарын мөнгөн дүн 56.0 мянган төгрөг нэг шуудай гурилын үнэд хүрэхгүй байна.

Үүнээс үзэхэд хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээ нь зорилтод бүлгийн иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, ядуурлыг бууруулахад бодитой дэмжлэг болж чадахгүй байна.

Аудитаар Өлгий сумын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг зарим айл өрхүүдийг сонгон шалгаж үзэхэд өрхийн амьжиргааны түвшин дээшилсэн айлууд байсан бөгөөд Амьжиргаа дэмжих зөвлөл үр дүнтэй хяналт тавьж ажиллаагүй байна.

2.4.6 Хүнс тэжээлийн дэмжлэг авсан иргэдийг журамд заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулан ажиллажээ

Өрхийн хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай боловч хөдөлмөр эрхлээгүй гишүүнд хүнсний эрхийн бичгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдах нөхцөлтэйгөөр олгож, хөдөлмөрийн чадвартай иргэн хүнсний

эрхийн бичигт хамрагдах журамд заасан ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээнд хамруулан зөвлөгөө өгч ажилладаг байна.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд хүнс тэжээлийн дэмжлэг авдаг өрхийн гишүүдээс 2020 оны статистик мэдээгээр 1,018 иргэн, 2021 онд 790 иргэн ажил хайгч иргэнээр бүртгүүлсэн байна.

Хөдөлмөрийн насны ажил эрхлэх чадвартай иргэдийн тоо өссөн нь Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн А/32 дугаар тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/103 тушаалаар баталсан Хүнсний эрхийн бичгийн журмыг ард иргэдэд сурталчлан таниулж, хүнс тэжээлийн дэмжлэг авдаг өрхүүдийн хөдөлмөрийн насны ажил хөдөлмөр эрхлэх чадвартай иргэд заавал ажил хайгчаар бүртгүүлж ажил идэвхтэй хайсан байх, ажилд зуучлуулж, ажил хөдөлмөр эрхэлсэн байх гэсэн заалттай холбоотой нэмэгджээ.

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санд 2020 онд ажил хайгч иргэнээр бүртгүүлсэн 809 иргэнээс ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад 678 иргэн хамрагдаж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдэд 2020 онд 393 иргэн, 2021 онд 790 иргэн бүртгүүлсэн байна.

Үүнээс 2020 онд 109 иргэн хөдөлмөрт бэлтгэх сургалтад, 199 иргэн нийтийг хамарсан ажилд /түр ажлын байр/, 24 иргэн мэргэжил олгох сургалтад хамрагдаж, 61 иргэн байнгын ажлын байртай болжээ.

Хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн мэдээллийн санд 2021 онд ажил хайгчаар 790 иргэн бүртгүүлж, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдэд 515 иргэн хамрагдсан байна.

Хүнсний эрхийн бичгийн heb2017 цахим программ нь хөдөлмөр эрхлэлтийн программтай уялдаагүй тул ХЭБ-ийн үйлчилгээ авч байгаа иргэдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой нарийн мэдээллийг тус программаас бүрэн гаргах боломжгүй байна.

БҮЛЭГ 3. ХАЛАМЖИЙН САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА

3.1 Халамжийн сангийн үйл ажиллагааны тайлан, мэдээг хугацаандаа тайлагнаж ажилласан байна

3.1.1 Нийгмийн хөгжлийн үйлчилгээ, халамжийн үйлчилгээний тайлангийн үр дүнг тооцож, холбогдох газарт тайлагнаж ажилласан байна

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Халамжийн сангийн 2020-2021, 2022 оны эхний хагас жилийн байдлаар төрөөс халамжийн сангаас олгож буй хөрөнгийн үр дүнг тооцож, мэдээ судалгааны хамт холбогдох газарт тайлагнаж ажилласан байна.

Сумууд халамжийн үйлчилгээ тус бүр дээр арилжааны банкинд данстай байсан бөгөөд 2016 оноос эхлэн эдгээр данснууд нь хаагдаж, аймгийн хэмжээнд нэгдсэн нэг данстай болсны улмаас сумууд халамжийн орлого, зарлагын мэдээг нэгтгэж өгдөггүй болж, зөвхөн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэний тоо, олгогдсон мөнгөн дүнгийн талаар статистик тоо мэдээллээр судалгаа гаргаж өгдөг болсон байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлтөд хамрагдсан иргэдийн тоо болон олгосон мөнгөн дүнг халамжийн сангийн

олголтын WAIS программаас сар бүр аймгийн хэмжээнд татан авч ХХҮЕГ-т “Нийгмийн халамжийн сангийн орлого, зарлагын мэдээ”, аймгийн Статистикийн хэлтэст “Нийгмийн халамжийн сангийн мэдээ”-г сар бүр өссөн дүнгээр тус тус гарган хүргүүлсэн байна.

Нийгмийн халамжийн сангийн орлого зарлагын мэдээг гаргахдаа авсан санхүүжилт болон зарлагын дүнгээр гаргадаг бөгөөд И-Халамж нэгдсэн системд шилжснээр аймаг, дүүргүүдэд санхүүжилтийн орлого олгодоггүй болсон тул цаашид улсын төсвийн санхүүгийн тайлан болон мэдээ гаргахгүй болж байгаа бөгөөд зөвхөн статистик тоон судалгааг гаргадаг болсон байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Цахим Монгол” хөтөлбөрийн хүрээнд халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлсэн байна.

Уг ажлын хүрээнд эхний элжинд 2020 онд Жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, Ихэр хүүхдийн тэтгэмж, 2021 онд Халамжийн тэтгэвэр, тэтгэмж, Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж, Өрх толгойлсон эх/ эцгийн тэтгэмж, Насны хишиг, Эхийн алдарт одонтой эхэд олгох мөнгөн тусламж, Алдар цолтон ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, тусламж, Хүүхдийн мөнгөн тэтгэмж цахимд шилжсэн байна.

2022 оны 2 дугаар сард Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт тусламж, Хүнсний эрхийн бичгийн хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээг үе шаттайгаар И-халамж нэгдсэн систем рүү шилжүүлснээр халамжийн бүх төрлийн үйлчилгээ цахимжсан байна.

Үүнтэй холбоотойгоор ХХҮЕГ нь нэгдсэн төсөвтэй болж Аймаг, дүүргийн ХХҮГ-ын Арилжааны банкин дахь данс руу санхүүжилт шилжүүлэхгүйгээр Сангийн яамнаас иргэдийн нэрийн данс руу шууд шилжүүлдэг болсон тул тухайн үйлчилгээнүүд И-халамж рүү шилжих хүртэл аймаг, дүүргүүдэд санхүүжилт олгож, шилжнээс хойш санхүүжилтийг зогсоосон байна.

Улирлын болон жилийн эцсийн санхүүгийн тайланг ХХҮЕГ болон аймгийн төрийн сангийн хэлтэст хуулийн хугацаанд хүргүүлэн ажиллаж ирсэн байна.

ХХҮГ-аас нийгмийн халамжийн сангаас үйлчилгээ авч буй иргэдийн тоо, зарцуулсан хөрөнгийн талаарх мэдээллийг холбогдох судалгааны хамт харьяа дээд байгууллагад хугацаанд нь хүргүүлж, санхүүгийн тайланд тусган ажилласан байна.

Аймгийн халамжийн сан нь 2020 онд төсвөөс 20,173.6 сая, бусад орлогоос 2.9 сая, хүүгийн орлогоос 9.9 сая, нийт 20,186.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнд 20,277.0 сая төгрөгийг, 2021 онд төсвөөс 8,484.3 сая, бусад орлогоос 1.8 сая, нийт 8,486.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээнд 8,460.1 сая төгрөгийг, 2022 оны эхний хагас жилийн байдлаар улсын төсвөөс 223.5 сая төгрөгийн санхүүжилт авсныг санхүүгийн тайланд тусгаж тайлагнасан байна.

Төсөвт 2020 онд 111.5 сая төгрөгийг, 2021 онд төсөвт 28.5 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.1.2 Халамжийн үйлчилгээг цахимаар мэдээлж байгаа нь иргэдэд хүртээмжтэй биш байна

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас Халамжийн сангийн үйл ажиллагаатай холбоотой 2020 онд ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулагдаагүй байна.

Ард иргэдэд халамжийн үйлчилгээг нээлттэй, чирэгдэлгүй хүргэх үүднээс халамжийн үйлчилгээг цахимжуулах ажлыг 2020 оноос эхлэн хийж Засгийн газрын 2020 оны 194 дүгээр тогтоолын дагуу 8 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн E-halamj системийн үйлчилгээг үзүүлж эхэлсэн байна.

Халамжийн үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, e-halamj цахим системд шилжүүлэх, сурталчлах ажлын хүрээнд 2021 оны 9 дүгээр сард аймгийн төв талбайд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж, ард иргэдийг мэдээ, мэдээллээр ханган, e-halamj цахим системд бүртгүүлэх, цахимаар хүсэлт гаргах талаар зааварчилгаа өгч гарын авлага тараасан байна.

Цар тахлын нөхцөл байдал үүссэн 2020 онд цахим хэлбэрээр дараах мэдээллүүдийг байршуулсан байна. Үүнд: Ёс зүйн зөвлөлийн 2020 оны төлөвлөгөө, “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах” Засгийн газрын 2018 оны 258 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, өргөдөл, гомдлын мэдээ, ёс зүйн зөвлөлийн холбогдолтой мэдээлэл, хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн 2020 оны хэрэгжилтийн талаарх мэдээллийг газрын вэб сайт, мэдээллийн самбарт тус тус байршуулсан.

2020 онд брошюрын агуулгыг боловсруулж, хэвлэн нийлүүлэх байгууллагыг сонгон шалгаруулж хэвлүүлэн, хараагүй иргэдийн хүртээл болгож, бүрэн хараагүй 1 иргэнд тусгай хэрэгсэл захиалж авч өгчээ.

Байгууллагын дотоод нэгжүүдээс 2021 онд байгууллагын цахим хуудсанд байршуулах мэдээ, мэдээллийг тухай бүр урьдчилан авч хяналт тавьж баталгаажуулсны дараа байршуулж, ард иргэдэд нээлттэй, хүртээмжтэй байдлаар хүргэсэн байна.

Иргэд, олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд салбарын холбогдох хууль тогтоомж, шийдвэрийн талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх ажлыг удаа дараа зохион байгуулж, зорилтот бүлгийн иргэдийн төрийн үйлчилгээнд хамрагдах боломжийг нэмэгдүүлэх талаар тодорхой ажлуудыг зохион байгуулсны үр дүнд зорилтот бүлгийн иргэд төрийн үйлчилгээнд хамрагдах боломжтой болсон байна.

Төрийн болон халамжийн үйлчилгээг 2022 онд E-mongolia, e-halamj цахим системээр ард иргэдэд хөнгөн, шуурхай үйлчилсэн байна. Байгууллагын тайлан мэдээг мэдээллийн самбарт байршуулан, мөн байгууллагын www.hudulmur-halamj.gov.mn цахим хуудсанд тухай бүр байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангаж ажилласан байна.

Нийгмийн халамжийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг бичгээр болон утсаар тогтмол авч тухай бүр судлан шийдвэрлэж хариу өгч, холбогдох мэргэжилтнүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлсэн байна.

Иргэдийн санал хүсэлтийг хүндрэл чирэгдэлгүй, шуурхай шийдвэрлэхэд анхаарч, иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар нэгдсэн мэдээлэл бэлтгэн мэдээллийн сувгаар түгээх ажлуудыг хийж, байгууллагын цахим хуудаст байршуулжээ.

Иргэдийн хүсэлтийн дагуу тухайн өрхөөр зочлон үнэлгээ хийх тохиолдолд ариутгал, халдваргүйжүүлэлтийн дэглэмийг сахиж, амьжиргааны түвшний үнэлгээг тооцож ажилласан байна.

2020 онд нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж, үйлчилгээтэй холбоотой 188, 2021 онд 195, 2022 оны эхний хагас жилд 125 өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг вэб сайт, байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулж, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг холбогдох байгууллагаар хянуулан мэдээллийн бусад хэрэгслээр байршуулж мэдээлж, цахим хуудасны мэдээллийг тогтмол шинэчилж ажилласан байна.

Нийгмийн халамжийн тухай хууль, тогтоомжийг иргэдэд сурталчлах нээлтэй хаалганы өдөрлөгийг 2022 онд 7 суманд, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаарх хууль тогтоомж, дүрэм журмыг олон нийтэд сурталчлах сарын аяныг бүх сумдад зохион байгуулж байгууллагын цахим хуудас, орон нутгийн радио, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилжээ.

Е-халамж цахим хуудсанд нийгмийн халамжийн үйлчилгээ авах иргэн хэрхэн бүртгүүлэх, мэдээллийг шинэчлэх, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар гарын авлага бэлтгэн түгээж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, вэб сайтаар сурталчилсан байна.

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас нийгмийн халамжийн үйлчилгээг цахимаар хүргэх талаар сурталчилж ажилласан боловч иргэдийн дунд явуулсан санал асуулга, мөн аудитын явцад Өлгий сумын багуудаар эмзэг бүлгийн айлуудаар орж авсан санал асуулгад хамрагдсан иргэдийн дийлэнх хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээлэл дутмаг, мэдээллийг цахимаар бус ХХҮГ-аас болон бусад эх үүсвэрээс олж авдаг гэсэн хариу өгчээ.

Үүнээс үзэхэд нийгмийн халамжийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэж байгаа боловч зорилтот бүлэг болон иргэдэд хүртээмжтэй болж чадаагүй байна.

3.1.3 Шилэн дансны мэдээллийг хугацаанд байршуулж ажилласан байна

Тус аудитын газраас Аймгийн Халамжийн сангийн 2020, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж, дүнг аудитын тайланд тусгасан байна. 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 мэдээллийг дутуу оруулсан зөрчилд зөвлөмж өгсөн ба 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хэрэгжилттэй холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

Аймгийн Нийгмийн халамжийн сан нь 2022 оны эхний хагас жилийн байдлаар халамжийн сангийн үйл ажиллагаатай холбоотой 49 мэдээллээс шилэн дансанд 48 мэдээллийг хугацаандаа оруулж, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.2 Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг 2020-2021 онд цахимаар хэрэгжүүлсэн нь үр нөлөөгүй байна

3.2.1 ХХҮЕГ-аас халамжийн сангийн 2020-2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит, мониторинг хийж, дүгнэлт гаргаагүй байна

ХХҮЕГ-аас тус аймгийн халамжийн сангийн 2020-2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит, мониторинг хийж, дүгнэлт гаргаагүй байна.

Ковид-19 цар тахлын нөхцөл байдал үүссэн 2020-2021 онуудад халамжийн үйлчилгээг хөнгөн шуурхай, чирэгдэлгүй олгох үүднээс халамжийн сангаас үзүүлэх үйлчилгээг цахимжуулах үйл ажиллагааг үе шаттайгаар зохион байгуулж, 2022 оноос халамжийн үйлчилгээг цахимаар олгох ажил бүрэн хийгдэж дууссан байна.

Нийгмийн халамжийн зарим төрлийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг 2020 оноос эхэлж, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгох үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор зарим төрлийн үйлчилгээг иргэний нэрийн

данс, ebarimt-нд холбуулсан дансаар болон e-halamj нэгдсэн системээр бүртгүүлэх ажлыг 2020 онд хийсэн байна.

Нийгмийн халамжийн зарим төрлийн үйлчилгээг иргэний нэрийн дансанд шилжүүлэх ажлыг арилжааны банкуудтай хамтран үе шаттайгаар зохион байгуулсан байна.

Программын өдөр тутмын хэвийн ажиллагааг хангаж, нийгмийн халамжийн төвлөрсөн мэдээллийн сан бүрдэж, улсын хэмжээнд нэвтрүүлсэн системийн ашиглалт сайжирч алдаа гарах нь багасжээ. Программтай холбоотой гарсан санал, гомдлыг дээд байгууллагад тухай бүр хүргэж, алдааг арилгуулж ажилласнаар систем нь доголдолгүй хэвийн ажиллаж иржээ. Мэдээллийн нэгдсэн сан бий болсноор халамжийн үйлчилгээ авах аливаа иргэн халамжийн ямар нэгэн үйлчилгээнд давхар хамрагдах боломжгүй болж, хяналт сайжирсан байна.

Халамжийн мэргэжилтэн нарын программд нэвтрэх нууц үгийг нээн өгч мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажилласан байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээг цахимжуулах явцад ХХҮЕГ-аас ирсэн зөвлөмжийн дагуу бэлтгэл ажлыг хангаж аймаг, сум орон нутагт ажиллаж байгаа мэргэжилтэн нарыг тогтмол арга зүйгээр хангаж ажиллажээ.

ХХҮГ нь 2021 онд өндөр хурдны шилэн кабелд холбогдож, сум хариуцсан 19 мэргэжилтэнд Юнителийн гэр интернет худалдаж авч өгснөөр салбарын хэмжээнд ашиглах программ хангамж, сүлжээний ямар нэгэн асуудалгүй ажиллах болсон байна.

Нийгмийн Халамжийн сангаас олгож байгаа бүх төрлийн үйлчилгээнүүд 2022 оноос цахим системд бүрэн шилжсэн байна.

Жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, Ихэр хүүхдийн тэтгэмж, Гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмжийн үйлчилгээнүүд 2020 оны 2 дугаар сараас орон нутагт дансгүй болж ХХҮЕГ-ын нэгдсэн дансаар олгож эхэлсэн байна.

2022 оны эхний хагас жилээс Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт тусламжийн үйлчилгээг хуучин системээс E-halamj.mn систем рүү шилжүүлснээр халамжийн бүх төрлийн үйлчилгээг E-halamj.mn системээр олгодог болсон байна.

3.2.2 ХХҮГ-аас 2020-2021 онд дотоодын хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна

ХХҮГ-аас 2020 онд сумдад нийгмийн халамжийн сангийн олголт, зарцуулалтад дотоодын хяналт шинжилгээ, дотоод аудит хийгдээгүй байна. Харин хяналтыг цахимаар хэрэгжүүлж ажилласан байна.

Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний Ерөнхий газрын даргын 2019 оны 2 дугаар сарын 13 -ны өдрийн Өрхийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлтэд хяналт, шалгалт хийх тухай А/18 дугаар тушаалын дагуу 2018 оны 07 дугаар сараас хойш өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд шинээр хамрагдсан болон дахин хамрагдаж өрхийн амьжиргааны түвшний үнэлгээ нь 670 буюу түүнээс доош оноотойгоор үнэлэгдсэн нийт 197 өрхөд хийсэн дотоод хяналт, шалгалтын анализыг ХХҮЕГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.

Тухайлбал: Өрхийн мэдээллийн нэгдсэн санг удирдах, ашиглах журамд зааснаар иргэн, хуулийн этгээд нь энэ журмын 2.2.3-т заасан өөртэй нь холбоотой мэдээллийн талаарх лавлагааг өгч, судалгаа авсан өрхийн мэдээллийг тухай бүр мэдээллийн санд оруулсан байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн сантай холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг иргэдэд ямар нэгэн чирэгдэлгүй үзүүлж шинээр төрсөн 3,138 хүүхэд, цар тахалтай холбоотой судалгаа авахгүйгээр хүүхдийн мөнгө цэсэд 226 хүүхэд болон дээрх хугацаанд гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэний хүүхдийн мөнгийг итгэмжлэлээр олгохтой холбоотой 6 өрхийн хүүхдийг бүртгэжээ.

2021 онд Өрхийн мэдээллийн нэгдсэн сантай холбоотой өдөр тутмын үйл ажиллагааг иргэдэд ямар нэгэн чирэгдэлгүй үзүүлж шинээр төрсөн 1,775 хүүхэд, цар тахалтай холбоотой судалгаа авахгүйгээр хүүхдийн мөнгө цэсэд 102 хүүхдийг бүртгэсэн, 2022 онд КАМ-ын бүртгэлгүй хаягийн зөрчилтэй гэх мэдээллийн зөрүүтэй 506 хүүхдийн мэдээллийг засварлуулан нөхөн олголтыг нь хийж дуусгасан байна.

Өрхийн мэдээллийн нэгдсэн санд 2022 онд 20,419 өрхийн мэдээллийг цуглуулж нийгмийн халамжийн аливаа тэтгэмж, хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдах боломж бололцоог бүрдүүлж, нийт 182 иргэний амьжиргааны түвшний тодорхойлолт гаргаж холбогдох байгууллагуудад уламжилжээ.

ХХҮЕГ-ын даргын 2014 оны 143 дугаар тушаалаар батлагдсан Дахин үнэлгээний систем ажиллуулах зааврын дагуу судалгаанд хамрагдаагүй болон дахин үнэлгээ хийлгэх хүсэлтэй нийт 156 өрх байгаа ч халдвар цар тахлын үед айл өрхөд зочилж судалгаа авах үйл ажиллагаа зогсонги байдалтай байгаа учир нэн шаардлагатай 26 өрхийн судалгааг хийж гүйцэтгэсэн байна.

Аймгийн ХХҮГ-ын бүтцэд Захиргаа, хяналтын хэлтэс нь 3 орон тоогоор хяналт шинжилгээ, үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэж ирсэн байна.

Албан тушаалын байрны тодорхойлолтод хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгмийн халамжийн зорилт, арга хэмжээний биелэлт байгууллагын дотоод үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хариуцахаар заасан байна.

ХХҮГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2021 оны 9 дүгээр сард Баяннуур, Булган, Дэлүүн, Толбо, Ногооннуур, Өлгий сумдад байнгын асаргааны тэтгэмж, өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж, тэжээгч алдсаны тэтгэмж, халамжийн тэтгэвэр, хүнсний эрхийн бичиг зэрэг үйлчилгээний хувийн хэргийн бүрдүүлэлт, олголтыг шалгаж, гарсан зөрчил дутагдлыг арилгуулах үүрэг даалгавар өгсөн байна.

Мөн ХХҮГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 6 дугаар сард Алтай, Алтанцөгц, Бугат, Буянт, Булган, Дэлүүн, Ногооннуур, Толбо, Улаанхус, Сагсай, Цагааннуур, Цэнгэл, Өлгий зэрэг 13 сум, 1 тосгонд нийгмийн халамжийн сангийн 2022 оны зарцуулалт, нийгмийн халамжийн тэтгэвэр, халамжийн тэтгэмжийн, өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний хувийн хэргийн бүрдүүлэлт, сангийн цахим системийн олголт зэргийг газар дээр нь шалгасан байна.

Сумдын байнгын асаргааны тэтгэмж авч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн заримыг биечлэн ирүүлэн, байнгын асаргааны тодорхойлолтод байгаа онош зэрэгтэй тулгаж, халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ

авч байгаа иргэдийн хувийн хэргийн бүрдүүлэлт, олголтыг шалгаж, гарсан зөрчлүүдийг арилгуулах талаар чиглэл өгч ажилласан байна.

ХХҮГ-ын дотоод хяналтын нэгжээс 2021-2022 онд хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөө, удирдамжийн дагуу дээрх сумуудад хяналт шалгалт хийсэн боловч энэхүү гүйцэтгэлийн аудитаар Алтай, Булган, Буянт, Өлгий сумын халамжийн сангаас хууль тогтоомж зөрчиж олгосон нийт 419.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн асуудлыг илрүүлж чадаагүй байгаагаас үзэхэд дотоодын хяналт шалгалт сул, чанаргүй, үр дүнгүй хийгдсэн гэж үзэх үндэстэй байна.

Аудитын дүнгээр аймгийн ХХҮГ-т аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, дахин давтан гаргахгүй байх, дотоодын хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, албан хаагч нарын ажлын сахилга хариуцлагыг сайжруулах талаар албан шаардлага өгч, албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн 6 албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

3.2.3 Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээнд шалгалт хийсэн байна

Аймгийн Мэргэжлийн хяналтын байгууллагын 2021 оны урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын баталсан 2021 оны 01/71 тоот удирдамж, “Төрийн хяналт шалгалтын тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, “Нийгмийн халамжийн тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хүнсний эрхийн бичиг олгох үйлчилгээнд өрх, иргэдийг хамруулсан байдал, зарцуулсан хөрөнгө, үр дүнд МХГ-аас шалгалтыг 2021 оны 8 дугаар сарын 15-ний өдрөөс 9 дүгээр сарын 10-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэсэн байна.

Энэхүү шалгалтад Нийгмийн халамжийн сангийн 2020 он, 2021, оны эхний 3 сарын санхүүгийн баримт, сангийн мэдээ, санхүүгийн тайлан, Өрхийн мэдээллийн сангийн судалгаа, тухайн газраас хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүрүүдийг сонгон шалгаруулсан баримт бичиг болон хүнсний дэлгүүрүүдтэй хийсэн гэрээ, гэрээний биелэлтийг дүгнэсэн материал, өрх-иргэний амьжиргааны түвшний үнэлгээний жагсаалтыг олон нийтэд ил тод байршуулсан эсэх, мөн ХХҮГ-ын дотоод хяналт шалгалтаар хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдсан өрх, иргэд, үйлчилгээ үзүүлэх дэлгүүрүүдийн үйл ажиллагаа, хүнсний эрхийн бичиг олголтод тавьж буй хяналт шалгалт, авсан арга хэмжээ санал дүгнэлт, амьжиргааг дэмжих зөвлөлөөс гаргасан шийдвэр зэрэг баримт материалыг хамруулсан байна.

Өлгий сумын 1,336 өрх, 7,339 иргэнд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх 33 хүнсний дэлгүүрээс хүнсний цахим эрхийн бичиг олгох, түүгээрээ хүнсний бүтээгдэхүүн худалдан авахад хамтран ажиллах гэрээний хэрэгжилт, хүнсний бүтээгдэхүүн олголтын кассын тайлан, НӨАТ-ын баримт олголт, ХХҮГ-ын тайлан гаргалт, ХХҮГ-аас гаргасан жагсаалтад заасан өрхийн гишүүн-иргэний цахим карт олголт, хүнсний бүтээгдэхүүний нэр төрөл зах зээлийг дундаж үнээр олгогдож байгаа байдлыг шалгалтад хамруулсан байна.

Шалгалтаар Улсын бүртгэлийн хэлтэст нас барсан, хаяг байршил өөрчлөгдсөн шилжин явсан иргэдийн мэдээллийг ирүүлж, хамтран ажиллах, сумдын Засаг дарга нарт Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 тушаалаар батлагдсан “Хүнсний эрхийн бичиг олгох журам”-ын 6.6-д сумын Засаг дарга нь суманд хүнсний эрхийн бичгээр үйлчлэх дэлгүүр сонгон шалгаруулах ажлыг

холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах журмын хэрэгжилт, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх дэлгэрэнгүй судалгааг ирүүлэх тухай МХГ-ын албан бичгийг тус тус хүргүүлэн ажилласан байна.

МХГ-ын шалгалтын дүнгээр улсын байцаагчийн 5 заалт бүхий хугацаатай зөрчил арилгуулах албан шаардлага, 3 заалт бүхий зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллажээ.

ХХҮГ-аас МХГ-аас өгсөн албан шаардлагын мөрөөр 7 төрлийн ажил зохион байгуулж, дүнг хугацаандаа хүргүүлсэн байна.

Дүгнэлт:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Халамжийн бодлого нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой уялдаагүй байна.
2. Орон нутгийн төсвөөс халамжийн үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг төлөвлөсөн хэмжээнээс бууруулж баталсан байна
3. Халамжийн үйлчилгээг хууль журмын дагуу үзүүлсэн байна
4. Халамжийн тэтгэврийн сангаас 125 иргэнд 417.4 сая төгрөгийн халамжийн тэтгэвэрийг хууль зөрчиж олгосон байна

5. Хүнсний эрхийн бичгээр үйлчилдэг дэлгүүрүүдэд хяналт тавьж ажиллаагүй байна
6. Хүнс тэжээлийн дэмжлэг нь ядуурлыг бууруулж, зорилтод бүлгийн иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэхэд төдийлөн нөлөө үзүүлээгүй байна
7. ХХҮГ-аас дотоодын хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
E-mail: bayan-ullgii@mol.gov.mn
Утас /факс/: (976) 7042-2428

2022.р. 28 № 1/417
танай _____-ны № _____ - т

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Нийгмийн халамжийн сангийн 2020-2021 он болон 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн аудитын шалгалтын тайлантай танилцав. Нэмж хүргүүлэх санал байхгүй болно.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А.ГАЛИЯ



ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Галия-д:

1. Сум, багуудын Амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагаатай тогтмол танилцаж, хяналтыг хэрэгжүүлж, ажлын баримт, тайлан судалгаа гаргаж ажиллах;
2. Сум, багуудын Амьжиргааг дэмжих зөвлөлүүдэд хурлын тэмдэглэл, ажлын тайлан мэдээ, судалгааг архивлаж хадгалах, баримт бичгийн эмх цэгцийг сайжруулах, ирцийн бүртгэл хөтлөх;
3. Халамжийн үйлчилгээг үзүүлэхдээ давхцалыг тооцож, хичнээн хүн халамжийн үйлчилгээнд хамрагдаж, хэдэн төрлийн үйлчилгээ авч байгаа талаар мэдээлэл, судалгаагаар болох;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ НЭГДСЭН ТАЙЛАНГИЙН ЗӨВЛӨМЖИД ОРУУЛАХ САНАЛ:

Халамжийн сангийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, холбогдох журамд дараах өөрчлөлтүүдийг оруулахаар Хөдөлмөр, нийгэм хагааллын яаманд хүргүүлэхээр санал болгож байна.

1. Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот эмзэг бүлгийн иргэнийг тодорхойлох босго шугамын оноог шинэчлэн тогтоох шаардлагатай байна

2. “Алсын хараа-2050”-д заасан амьдралын баталгааг хангах нийгмийн хамгааллын үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах.

3. Халамжийн бодлогыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой үр дүнтэй уялдуулах.

БӨА ТАГ ТУШААЛ



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 28 өдөр

Дугаар А/23

Өлгий

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын хавсралтын 18 дугаар хэсгийн 18.9, 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Аймгийн Халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө" сэдвээр хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай

2. Аудитын тайланг Дорнод аймаг дахь Төрийн Аудитын газар, аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд ирүүлэхийг аймгийн Хөдөлмөр, Халамж үйлчилгээний газрын даргын албыг түр орлон гүйцэтгэгч /А.Галия/-д зөвлөсүгэй.

4. Аудитын дүнгээр өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг ахлах аудитор /Х.Манаргүл/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Х.Женисбек/-т тус тус даалгасугай.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

ХАВСРАЛТУУД

Хавсралт №1

Аймгийн нийгмийн халамжийн сангийн 2020-2022 оны орлого ба зарцуулалтын задаргаа

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Орлого			Зарцуулалт				Эцсийн үлдэгдэл
		Санхүүжил тийн орлого	Бусад орлого	Хүүгийн орлого	Төсвөөс	Олгодоогүй мөнгөний зарцуулалт	Банкны шимтгэл	Төсөвт төвлөрүүл сэн	
2020 он									
Нийгмийн халамжийн тэтгэвэр	77.3	8,974.5	2.7	1.1	9,005.30	46.4		3.8	
Нийгмийн халамжийн тэтгэмж	6.9	1,766.7		0.6	1,768.60	3.2		2.4	
Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж	17.7	1,514.1		0.5	1,529.70			2.6	
Жирэмсэн эхийн тэтгэмж	21.8	65.0		0.7	86.91			0.56	0.1
ХБИ-нд үзүүлэх тусламж	2.6	862.4		0.3	864.9			0.4	
Хүнс тэжээл	44.3	3,389.60		1.3	3,433.90			1.3	
Алдарт эхийн одонгийн тусламж	1.8	1500		2.9	1,446.00	0.9		56.5	1.3
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	0.0	119.4		0.5	119.1			0.5	0.3
Насны хишгийн санхүүжилтийн орлого	15.4	595.7		0.8	595.3	0.9		15.1	0.5
Цалинтай ээж хөтөлбөр	5.0	288.6	0.2	0.6	283			10.7	0.2
Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр	1.3	162.5		0.1	157.4	0.3		6.2	
Ахмад насинуудад үзүүлэх хөнгөлөлт	10.6	848.2		0.4	857.8			1.4	
АДЗ-ийн урамшууллын санхүүжилт	-	32.1			32.1				
Банкны шимигэлийн санхүүжилт	-	6.8			6.8				
Ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмжийн санхүүжилт	-	48.0			38.0			10	
Нийт орлого	204.7	20,173.6	2.9	9.9	20,225.3	51.7		111.5	2.4
2021 он									
Нийгмийн халамжийн тэтгэвэр		1,918.0			1,901.3			16.7	0.0
Нийгмийн халамжийн тэтгэмж		1,568.7			1,568.7				-
Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж		1,522.7			1,522.7				-
Жирэмсэн эхийн тэтгэмж	0.1	-		0.0			0.0	0.1	0.0
ХБИ-нд үзүүлэх тусламж		596.1			596.1				-
Хүнс тэжээл		1,983.1	1.8		1,978.5			6.4	(0.0)
Алдарт эхийн одонгийн тусламж	1.3			0.0			0.0	1.3	0.0
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	0.3			0.0			0.0	0.3	(0.0)
Насны хишгийн санхүүжилтийн орлого	0.5			0.0			0.0	0.5	(0.0)
Цалинтай ээж хөтөлбөр	0.2			0.0			0.0	0.2	(0.0)
Ахмад насинуудад үзүүлэх хөнгөлөлт		865.7			865.7				-
АДЗ-ийн урамшууллын санхүүжилт		24.1			23.9			0.2	(0.0)

Аймгийн Халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө

Банкны шимигэлийн санхүүжилт		6.0			3.2			2.8	-
Нийт орлого	2.4	8,484.3	1.8	0.0	8,460.0	-	0.1	28.5	0.0
2022 он									
ХБИ-нд үзүүлэх тусламж		20.7			17.0		3.7		0.0
Хүнс тэжээл		138.5			138.3		0.2		(0.0)
Ахмад насинуудад үзүүлэх хөнгөлөлт		68.2			68.2				-
Нийт орлого	-	227.3	-	0.0	223.5	-	3.8	-	0.0

Хавсралт №2

Халамжийн сангийн 2020-2022 оны батлагдсан төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Батлагдсан төсөв		Гүйцэтгэл		Зөрүү	
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн
2020 он						
Нийгмийн халамжийн тэтгэвэр	3744	8974.5	3187	9051.7	-557	77.2
Нийгмийн халамжийн тэтгэмж	2685	1766.7	1679	1771.8	-1006	5.1
Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж	1990	1514.1	1572	1529.7	-418	15.6
Жирэмсэн эхийн тэтгэмж	2337	65.0	1065	86.9	-1272	21.9
ХБИ-нд үзүүлэх тусламж	4428	862.4	3912	864.9	-516	2.5
Хүнс тэжээл	18200	3389.6	14651	3433.9	-3549	44.3
Алдарт эхийн одонгийн тусламж	10200	1500.0	10543	1446.9	343	(53.1)
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	182	120.6	147	119.1	-35	(1.5)
Насны хишгийн санхүүжилтийн орлого		595.7	3819	596.3	3819	0.6
Цалинтай ээж хөтөлбөр	6200	288.6	5582	283.4	-618	(5.2)
Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр	300	162.5	164	157.7	-136	(4.8)
Ахмад насинуудад үзүүлэх хөнгөлөлт	4734	848.2	7842	857.8	3108	9.6
АДЗ-ийн урамшууллын санхүүжилт		32.1		32.1	0	(0.0)
Банкны шимтгэлийн санхүүжилт		6.8		6.8	0	0.0
Ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмжийн санхүүжилт	40	48.0	19	38.0	-21	(10.0)
Нийт дүн	55040	20174.7	54182	20277.0	-858	102.3
2021 он						
Нийгмийн халамжийн тэтгэвэр	5646	1918.0	2867	9630.4	-2779	7,712.4
Нийгмийн халамжийн тэтгэмж	4352	1568.7	1566	1832.45	-2786	263.8
Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж	2250	1522.7	1489	1805.2	-761	282.5
Жирэмсэн эхийн тэтгэмж			1044	472.52		
ХБИ-нд үзүүлэх тусламж	3120	596.1	2203	596.1	-917	0.0
Хүнс тэжээл	14251	1983.1	14497	1978.5	246	(4.6)
Алдарт эхийн одонгийн тусламж			11368	1530.7		
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж			61	13.9		
Насны хишгийн санхүүжилтийн орлого			3714	638.8		
Цалинтай ээж хөтөлбөр			5726	3349.89		
Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр			164	270.21		
Ахмад насинуудад үзүүлэх хөнгөлөлт	8421	865.7	10930	865.7	2509	0.0
АДЗ-ийн урамшууллын санхүүжилт		24.1	181	23.9		
Ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмжийн санхүүжилт			28	63		
Банкны шимтгэлийн санхүүжилт		6.0		3.2		
Нийт дүн	38040	8484.3	55838	23074.5	-4488	8254.2
2022 он						

Аймгийн Халамжийн сангийн үйл ажиллагааны үр нөлөө

Нийгмийн халамжийн тэтгэвэр			2661	4563.19		
Нийгмийн халамжийн тэтгэмж			1546	856.26		
Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж			1424	858.9		
Жирэмсэн эхийн тэтгэмж			1106	237.3		
ХБИ-нд үзүүлэх тусламж	3120	247.89	375	84.7	-2745	(163.2)
Хүнс тэжээл	1425	1960	10655	779.79	-3596	(1,180.2)
	1					
Алдарт эхийн одонгийн тусламж			11700	1578		
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж			17	12.48		
Насны хишгийн санхүүжилтийн орлого			3859	642.82		
Цалинтай ээж хөтөлбөр			6303	1811.87		
Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр			160	132.2		
Ахмад настануудад үзүүлэх хөнгөлөлт	8421	657.81	961	162.59	-7460	(495.2)
АДЗ-ийн урамшууллын санхүүжилт		31.1	161	6.95		
Банкны шимтгэлийн санхүүжилт		6				
Ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмжийн санхүүжилт			11	29		
Нийт дүн	25792	2902.8	40939	11756.05	-13801	-1838.62

Аймгийн Халамжийн сангийн 2020-2021 он болон 2022 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийг харьцуулсан судалгаа

Үзүүлэлт	2020 оныг гүйцэтгэл		2021 оныг гүйцэтгэл		2022 оныг гүйцэтгэл		Зөрүү /2021-2022/		Зөрүү /2022-2021/
	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо	Мөнгөн дүн	Хүний тоо
Нийгмийн халамжийн тэтгэвэр	3187	9051.7	2867	9630.4	2661	4563.19	-320	578.7	-206
Нийгмийн халамжийн тэтгэмж	1679	1771.8	1566	1832.45	1546	856.26	-113	60.7	-20
Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж	1572	1529.7	1489	1805.2	1424	858.9	-83	275.5	-65
Жирэмсэн эхийн тэтгэмж	1065	86.9	1044	472.52	1106	237.3	-21	385.6	
ХБИ-нд үзүүлэх тусламж	3912	864.9	2203	596.1	375	84.7	-1709	-268.8	
Хүнс тэжээл	14651	3433.9	14497	1978.5	10655	779.8	-154	-1455.4	-3842
Алдарт эхийн одонгийн тусламж	10543	1446.9	11368	1530.7	11700	1578	825	83.8	332
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	147	119.1	61	13.9	17	12.5	-86	-105.2	-44
Насны хишгийн санхүүжилтийн орлого	3819	596.3	3714	638.8	3859	642.82	-105	42.5	145
Цалинтай ээж хөтөлбөр	5582	283.4	5726	3349.9	6303	1811.87	144	3066.5	577
Өрх толгойлсон эх, эцэг хөтөлбөр	164	157.7	164	270.21	160	132.2	0	112.5	-4
Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт, тусламж	7842	857.8	10930	865.7	961	162.6	3088	7.9	-9969
АДЗ-ийн урамшууллын санхүүжилт	181	32.1	181	23.9	161	7.0	181	-8.2	-20
Банкны шимтгэлийн санхүүжилт		6.8	28	63			28	56.2	-28
Ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмжийн санхүүжилт	19	38.0		3.2	11	29	-19	-34.8	11
Нийт дүн	54182	20277.0	55838	23074.5	40939	11756.1	1656	2797.5	-13133